МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| НЭГ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА | | | | | | | |
| Стратегийн зорилго нэг: Монгол Улсын хууль, тогтоомж, бодлого, шийдвэрийг хүний эрхийн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэхэд хувь нэмрээ оруулах. | | | | | | | |
| МУХЭҮКТХ: 7.1.4.Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбогдсон хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай саналаа хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлах. | | | | | | | |
| 1.1 | Зорилт 1.1: Монгол Улсын хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын индекс боловсруулан батлуулах, Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачлалыг боловсронгуй болгож, хууль тогтоомж, тодорхой бодлого, шийдвэр, үйл ажиллагааны улмаас хүний эрхэд үзүүлэх сөрөг нөлөөллийг илрүүлэх, тодорхойлох, үнэлэх, арилгах буюу бууруулах цогц арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх. | | | | | | |
| 1.1.1 | Арга хэмжээ 1.1.1: Монгол Улсын хүний эрхийн үндэсний индекс боловсруулах. | Улсын төсөв | Боловсруулсан баримт бичгийн тоо | 0 | 1 | Монгол Улсын хүний эрхийн үндэсний индексийг 2 ангилалд (Иргэний болон улс төрийн эрхийн хүрээнд 13, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хүрээнд 7) 20 хэмжээсээр, нийт 54 үзүүлэлттэй, хэмжээс бүрд 2-4 үзүүлэлт байхаар тооцон боловсруулж дууссан. Индекс тооцох аргачлал, олон нийтээс болон шинжээчдээс авах асуулгын төсөлд тусгуулах саналыг ҮСХ-д хүргүүлээд байна. | 100 |
| 1.1.2 | Арга хэмжээ 1.1.2: Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид хүний эрхийн шалгуураар давхардал, хийдэл, зөрчлийг тодорхойлох, хэрэгжилтийг үнэлэх, дүн шинжилгээ хийх, санал хүргүүлэх. | Улсын төсөв | Сонгосон салбар дахь хууль тогтоомжид өгсөн саналын тоо | 0 | 1 | Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид хүний эрхийн шалгуураар давхардал, хийдэл, зөрчлийг тодорхойлох, хэрэгжилтийг үнэлэх, дүн шинжилгээ хийх ажлын хүрээнд 5 хуулийн төсөлд санал тусгуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн. Үүнд:<br>- УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хороонд “Нийгмийн даатгалын ерөнхий хууль”, “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль”-ийн төсөлд тусгуулах саналыг 2023.01.18-ны өдөр;<br>- ЗГХЭГ-т “Монгол Улсын Үндсэн хууль”-д оруулах өөрчлөлтийн төсөлд тусгуулах саналыг 2023.04.25-ны өдөр УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороонд 2023.05.16-ны өдөр тус тус;<br>- УИХ-ын Хүний эрхийн дэд хорооны дарга УИХ-ын гишүүн Д.Мөнхцэцэгт “Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн төсөлд тусгуулах саналыг 2023.05.23-ны өдөр; | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргилд “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуул”-ийн төсөлд санал боловсруулж, 2023.11.27-ны өдөр тус тус хүргүүлсэн.<br>2. Хууль тогтоомжид хүний эрхийн давхардал, хийдэл, зөрчлийг тодорхойлох, хэрэгжилтийг үнэлэх ажлын хүрээнд “Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилт”-тэй холбоотой баримт бичгүүдийг БОАЖЯ, ХНХЯ, УУХҮЯ, ЗТХЯ-аас авч, судлаач Р.Мөнхзул, П.Баттулга нарт шилжүүлж, судалгааны ажлыг эхлүүлсэн.<br>3. Дараах 6 хуулийн төсөлд тусгах саналыг боловсруулж, холбогдох газруудад хүргүүлэхээр бэлтгэж байна.<br>- Ахмад настны тухай хуулийн төсөл;<br>- Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл;<br>- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн төсөл;<br>- Саадгүй орчин, хүртээмжийн тухай хуулийн төсөл,<br>- Онц байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;<br>- Эрүүгийн хуулийн төсөлд “доромжлох”, “худал мэдээлэл тараах” гэмт хэргийг хасах үндэслэл, шаардлага. | |
| 1.1.3 | Арга хэмжээ 1.1.3: Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалыг хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар санал өгөх. | Улсын төсөв | Аргачлалыг шинэчлэн боловсруулахад өгсөн саналын тоо | 0 | 1 | УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 2023 оны 187 дугаар захирамжаар батлагдсан “Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлд хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх аргачлал”-ыг татан авч судлан, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалтай харьцуулан дүн шинжилгээ хийж, санал боловсруулах ажил хийгдэж байна.<br>Уг арга хэмжээ МУЗГ-ын 2023.06.14-ны өдрийн 231 дүгээр тогтоолоор батлагдсан "Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө (2023-2027)"-нд 2023-2024 онд Комиссоос бусад төрийн байгууллага, ТББ-уудтай хамтран хэрэгжүүлэхээр болсон. | 30 |
| 1.1.4 | Арга хэмжээ 1.1.4: Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлалын хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээнд үндэслэн санал өгөх. | Улсын төсөв, Төсөл хөтөлбөр | Хүргүүлсэн саналын тоо | 0 | 1 | Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/147 дугаар тушаалаар батлагдсан “Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал”-ыг сайжруулах саналын төслийг “Иргэний оролцооны зохицуулалт бүхий захиргааны хэм хэмжээний актад хийсэн дүн шинжилгээний үр дүн”, “ХЗДХЯ-аас зохион байгуулсан “ЗХХА-ын хуульд нийцсэн байдал, хоорондын уялдаа, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах асуудал” сэдэвт хэлэлцүүлгээс гарсан санал болон бусад судалгааны материалуудыг судлан боловсруулсан. | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Ханнс-Зайделийн сангийн зүгээс тус арга хэмжээг гүйцэтгэхэд шаардагдах зардлыг 2023 онд санхүүжүүлэх боломжгүй, 2024 оны төсөвт тусгах боломжтой талаар хариу өгсөн. | |
| 1.2 | Зорилт 1.2: Хүний эрхийг хангах, хамгаалах төрийн бодлого, хууль эрх зүйн орчныг сайжруулахад хувь нэмэр оруулах. | | | | | | |
| 1.2.1 | Арга хэмжээ 1.2.1: Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн хүрээнд тодорхойлсон болон хүний эрхийг хангах, хамгаалахад ач холбогдолтой хууль тогтоомжид санал өгөх.<br>- Хүүхдийн эрхийн тухай хууль;<br>- Гэр бүлийн тухай хууль;<br>- Ахмад настны тухай хууль;<br>- Боловсролын тухай багц хууль;<br>- Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль;<br>- Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль;<br>- Прокурорын тухай хууль;<br>- Цагдаагийн албаны тухай хууль;<br>- Эрүүгийн хууль;<br>- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль;<br>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль;<br>- Зөрчлийн тухай хууль болон холбогдох хуулиуд;<br>- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, болон холбогдох хуулиуд;<br>- Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль. | Улсын төсөв | Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 1. Сонгон авсан хуулиудаас дараах 5 хуулийн төсөлд санал боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн. Үүнд:<br>- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын загвар төсөл, түүний дагалдах хуулиудын загвар төслийг тус тус боловсруулж Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 илтгэлд тусгаж, УИХ-д хүргүүлсэн.<br>- УИХ-ын гишүүн Д.Мөнхцэцэгт Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд 2023.05.23-ны өдөр;<br>- УИХ-ын, Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, УИХ-ын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар, УИХ-ын гишүүн Ц.Сандаг-Очир нарт Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд 2023.10.31-ний өдөр;<br>- УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаярт “Гэр бүлийн тухай хууль”-ийн төсөлд 2023.12.06-ны өдөр тус тус санал хүргүүлсэн.<br>2. Дараах 8 хуулийн төсөлд санал авахаар холбогдох газраас хүсэлт ирүүлээгүй.<br>- Хүүхдийн эрхийн тухай хууль;<br>- Боловсролын тухай багц хууль;<br>- Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль;<br>- Прокурорын тухай хууль;<br>- Цагдаагийн албаны тухай хууль;<br>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль;<br>- Зөрчлийн тухай хууль болон холбогдох хуулиуд;<br>- Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль. | 100 |
| МУХЭҮКТХ: 7.1.2.Хууль тогтоомж, захиргааны байгууллагын шийдвэрийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар санал гаргах. | | | | | | | |
| 1.2.2 | Арга хэмжээ 1.2.2: Хууль тогтоомж, захиргааны | Улсын төсөв | Санал өгөх ажлын | 0 | 100 | 1. Монгол дохионы хэлний тухай хуулийн үзэл баримтлалыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх хүрээнд Комиссоос хийгдсэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагын шийдвэрийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар санал гаргах.<br>- Монгол дохионы хэлний тухай хуулийг боловсруулах Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх;<br>- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулж, Комиссын санал боловсруулах хэрэгцээг тодорхойлох;<br>- Хүний эрх хамгаалагчийн асуудлаар хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах чиглэлээр Комиссын санал боловсруулан хүргүүлэх;<br>- Төрийн бус байгууллагын тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгыг боловсруулахад оролцох. | | гүйцэтгэлийн хувь | | | хяналт шалгалт, Комиссын гишүүний шаардлагыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хэлний зөвлөлд хүргүүлсэн.<br>2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгын төслийн талаар хэлэлцүүлэгт Комиссын дарга, СДХШХ-ийн төлөөллүүд оролцож хуулийн төсөлд тусгуулах саналаа өгсөн. Комиссоос Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Саадгүй орчин, хүртээмжийн тухай хуулийн төсөлд тусгах саналыг боловсруулж хяналтад шилжүүлээд байна.<br>3. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Гэрч, хохирогчийг хамгаалах журамд нэмэлт оруулах саналыг Цагдаагийн ерөнхий газарт хүргүүлсэн.<br>Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд Комиссын Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүний ротацийн зохицуулалтыг өөрчлөх асуудлаар нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулсан.<br>4. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 илтгэлийн 2 дугаар бүлэг болох "Иргэний оролцооны эрх зүйн зохицуулалт бүлэг"-т Төрийн бус байгууллагын эрх зүйн зохицуулалт сэдвийг тусгаж УИХ-д хүргүүлсэн. | |
| МУХЭҮКТХ:7.1.12.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл боловсруулж, Улсын Их Хуралд хүргүүлэх. | | | | | | | |
| 1.2.3 | Арга хэмжээ 1.2.3: Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийг боловсруулах, өргөн барих, англи хэл рүү орчуулах, илтгэлийг хэвлүүлэх, сурталчлах, түгээх. | Улсын төсөв | Боловсруулж, сурталчилсан илтгэлийн тоо | 21 | 22 | 1. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийг "Халдашгүй чөлөөтэй байх эрх", "Иргэний оролцооны эрх зүйн зохицуулалт", "Хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал", "Хүүхдийн эрхийн зарим асуудал", "Ахмад настны эрхийн хэрэгжилт", "Хүний эрх хамгаалагчийн эрх, хамгаалалт", "Улс төрийн хүрээн дэх жендэрийн тэгш байдал" гэсэн 7 бүлэг сэдвээр бэлтгэсэн. Илтгэлийн хавсралтаар УИХ-аар шийдвэр гаргуулах санал, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын загвар төсөл, түүний дагалдах хуулиудын загвар төсөл болон ХЭҮК-ын гишүүний 2020 оны 11 дүгээр сараас хойш гаргасан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг боловсруулж УИХ-ын даргад 2023.03.29-ны өдөр өргөн мэдүүлсэн.<br>- Илтгэлийг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцсэнтэй холбогдуулан УИХ-ын 2023.05.04-ний өдрийн "Монгол Улс дахь | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүүл шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 35 дугаар тогтоол батлагдсан.<br>- Илтгэлийг нийт 1000 ширхэг хэвлүүлж төрийн захиргааны төв байгууллага болон түүний харьяа агентлаг, газар, нэгжүүд, аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗДТГ, Их дээд сургуулийн номын сан зэрэг 110 байгууллагад түгээсэн.<br>- Илтгэлийг сурталчлах ажлын хүрээнд цахим хувийг бүрэн эхээр нь Комиссын цахим хуудас, цахим номын санд байршуулж, бүлэг тус бүрээр нийт 24 постер, 1 шторк бэлтгэн Комиссын фейсбүүк, цахим хуудсаар түгээж, хэвлэл, мэдээллийн 140 гаруй байгууллагад 400 гаруй мэдээ, мэдээлэл, ярилцлага, сурвалжлаг, нийтлэл бэлдэж, олон нийтэд түгээх ажлын зохион байгуулсан.<br>- Илтгэлийг англи хэл рүү орчуулж дууссан ба цахим хувилбараар эх бэлтгэж, олон нийтэд түгээх ажил үргэлжилж байна. | |
| МУХЭҮКТХ: 7.1.1.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой аливаа асуудлаар санал, зөвлөмж гаргаж, эрх бүхий байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд хүргүүлэх; | | | | | | | |
| 1.2.4 | Арга хэмжээ 1.2.4: Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой аливаа асуудлаар Комиссын санал, зөвлөмж гаргаж, эрх бүхий байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд хүргүүлэх. | Улсын төсөв | Санал, зөвлөмж боловсруулах үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | Тайлант хугацаанд Комиссын санал, зөвлөмж гараагүй ба 2022 оны 12 дугаар сар, 2023 оны 1 дүгээр сард Жанжин Д.Сүхбаатарын талбайд өрнөсөн жагсаал, цуглааны үйл явцад Комисс 2022.12.04-ний өдрөөс 2023.01.10-ны өдрийн хооронд хяналт тавьж, баримтжуулалт хийсэн. Жагсаал цуглаанд оролцогчдын нэр төр, алдар хүндийг гутаах, тэднийг төлбөртэй болон захиалгаар жагссан гэх баталгаагүй мэдээллийг олон нийтэд хүргэх, эрүүгийн болон зөрчлийн хэрэгт холбогдуулан шалгах, тайван жагсаал цуглааныг албадан тараах зэргээр Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний үзэл бодлоо илэрхийлэх, тайван замаар жагсаал цуглаан хийх эрх чөлөөг хязгаарлах зөрчил, эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарсан. Тайван жагсаж цуглах эрх чөлөөний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, нөгөө талаар тайван замаар жагсах, хуран цуглах эрх чөлөөгөө эдлэхдээ нийгмийн хэв журмыг зөрчиж, бусад хүмүүсийн аюулгүй байдлыг алдагдуулсан, нийтийн эзэмшлийн эд зүйлсийг устгаж гэмтээсэн, хууль сахиулагч, төрийн алба хаагчийн эрх чөлөөнд халдсан, согтууруулах ундаа хэрэглэсэн, жагсаал цуглаанд бага насны хүүхдийг оролцуулсан, | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мал амьтан, шатамхай бодис ашигласан зэрэг хуулиар хориглосон үйлдэл гаргасан тохиолдолд цагдаагийн байгууллагаас хүний эрхийн зарчимд нийцсэн албадлын арга хэмжээ авах, эрх хэмжээгээ хэтрүүлэхгүй байх, энэ талаарх эрх зүйн зохицуулалт нэг мөр, тодорхой байх нь зохистой болох Дүгнэлтийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн. | |
| 1.3 | Зорилт 1.3: Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг шинэчлэн батлах, хэрэгжүүлэх чиглэлээр нөлөөллийн ажил зохион байгуулах. | | | | | | |
| 1.3.1 | Арга хэмжээ 1.3.1: Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд манлайлан оролцох. | Улсын төсөв | Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2023.06.16-ны өдрийн А/16 тушаалаар “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр II”-ийн төслийг боловсруулах ажлын хэсэг ЗГХЭГ-ын ХЭХҮХороо, Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц, МУИС-ХЗС, НҮБХХ, Комиссын дэргэдэх ИНЗ болон төрийн бус байгууллага, судлаачдын төлөөлөл нийт 14 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдан ажилласан. Комиссоос “Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр II”-ийн төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2023.11.08-ны өдөр 01/1378 албан бичгээр, УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд 2023.11.09-ний өдөр 01/1386 албан бичгээр, тус тус хүргүүлсэн. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 75 жилийн ойд зориулан 12 дугаар сарын 09-ний өдөр хийсэн Улсын Их Хурлын Хүндэтгэлийн хуралдаанд Улсын Их Хурлын дарга хэлсэн үгэндээ , тус хөтөлбөрийг баталж хэрэгжүүлэх амлалтаа танилцуулав. Мөн 2023 оны 12 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд Женев хотноо зохион байгуулагдсан “Хүний эрх-75” дээд, өндөр түвшний арга хэмжээнд Монгол Улс тус хөтөлбөрийг боловсруулж батлах талаар НҮБ-ын өмнө амлалт авсан. | 100 |
| 1.4 | Зорилт 1.4: Гамшгийн онцгой нөхцөл байдал, онц байдлын үед хүний эрхийг хангах, хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох. | | | | | | |
| 1.4.1 | Арга хэмжээ 1.4.1: Онц байдал зарласан эсхүл гамшгийн үед хүний эрхийг хангах, хамгаалж ажиллах үндэсний бодлого боловсруулахад чиглэсэн судалгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах.<br>- /КОВИД-19/ цар тахлын сургамжид үндэслэн гамшгаас хамгаалах, халдварт өвчинтэй тэмцэх тогтолцоо, чадавхыг дээшлүүлэх үйл ажиллагааг | Улсын төсөв | Нөлөөллийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | Комиссоос Онцгой байдлын хуулийн төсөлд саналыг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлсэн. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилтийг гаргаж, 2023.01.16-ны өдрийн 01/68 дугаар албан бичгээр УИХ-ын түр хороонд хүргүүлсэн.<br>Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн Байнгын хорооноос 2023.10.23,24-ний өдөр зохион байгуулагдах Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Ерөнхий | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөнд тусгах санал гаргах, энэ талаар байгууллагуудын хамтын ажиллагааг идэвхжүүлэх. | | | | | хяналтын сонсголд Комиссын дарга мэдээлэл хийв. /КОВИД-19/ цар тахлын сургамжид үндэслэн гамшгаас хамгаалах, халдварт өвчинтэй тэмцэх тогтолцоо, чадавхыг дээшлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр II”-ийн төсөлд холбогдох заалтыг тусгав | |
| Стратегийн зорилго хоёр. Хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд үр дүнтэй хяналт тавих, бодитой, эерэг өөрчлөлт гаргах | | | | | | | |
| 2.1 | Зорилт 2.1: Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрхийн хэрэгжилтэд үр нөлөөтэй хяналт тавих, энэ чиг үүргийг хэрэгжүүлэх арга зүйг боловсронгуй болгох. | | | | | | |
| 2.1.1 | Арга хэмжээ 2.1.1: Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ (ХЭНБҮ) хийх аргачлалын дагуу уул уурхайн болон хөгжлийн бусад төслийг үнэлэх, аргачлалыг сайжруулах. | Улсын төсөв, төсөл, хөтөлбөр | Турших, хэрэгжүүлсэн аргачлалын тоо | 0 | 1 | Комиссоос Ховд аймгийн Дарви сум дахь Хөшөөтийн уурхай, Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь “Оюу Толгой” уурхай, Дорнод аймгийн Халх гол, Матад сум дахь газрын тосны үйлдвэрийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөж буй иргэдээс судалгаа авах ажлыг хийж гүйцэтгэхэд тус аргачлалыг турших, аргачлалыг шинэчлэн сайжруулах шаардлагагүй гэж үзсэн. | 100 |
| 2.1.2 | Арга хэмжээ 2.1.2: Олон улсын шинжээчдийн оролцоотойгоор Монгол Улсын төсөвт Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн пактаар хүлээсэн үүргийг хэрэгжүүлж байгаа байдалд дүн шинжилгээ хийх аргачлал боловсруулах. | Улсын төсөв, төсөл, хөтөлбөр | Аргачлалын төслийн тоо | 0 | 1 | Олон улсын шинжээчдийн оролцоотойгоор “Монгол Улсын төсөвт эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн пактаар хүлээсэн үүргийг хэрэгжүүлж байгаа байдалд дүн шинжилгээ хийх аргачлал боловсруулах нь” төслийн баримт бичгийг боловсруулж хандивлагч байгууллагуудад хүргүүлэхээр ажиллаж байна. Мөн 2023.11.15-ны өдөр зохион байгуулсан “Тогтвортой хөгжил, хамтын ажиллагаа” уулзалтад оролцсон Монгол Улсад суугаа ЭСЯ, ОУБ-ын төлөөлөлд танилцуулсан. | 10 |
| 2.1.3 | Арга хэмжээ 2.1.3: Боловсролын салбар дахь хүний эрхийн зарим асуудлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.<br>- Дээд боловсролын салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх. | Улсын төсөв | Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн тоо | 0 | 1 | Дээд боловсролын салбар дахь хүний эрхийн асуудал судалгааны ажлыг “Оюуны Инноваци” ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлж, судалгааны үр дүнг хүлээн авсан ба Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлд тусган УИХ-аас холбогдох шийдвэрийг гаргуулахаар ажиллаж байна. | 100 |
| 2.1.4 | Арга хэмжээ 2.1.4: Хөдөлмөрлөх эрхийн салбарын судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн эрхийг хангах тогтолцоог сайжруулах үе шаттай үйл ажиллагааг хэрэгжүүлэх.<br>- Хөдөлмөрлөх эрхийн хүрээнд хийсэн судалгааны үр дүнг илтгэлд тусгах, холбогдох | Төсөл хөтөлбөр | Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 1. “Төрийн үйлчилгээний албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт”, “Төрийн тусгай албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт” судалгааны үр дүнг Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн 3 дугаар бүлэгт тусган Монгол Улсын Их Хуралдп танилцуулж улмаар УИХ-ын 2023 оны 35 дугаар тогтоолд Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж, авч хэрэгжүүлэх арга хэмжээг нэгдмэл байдлаар тодорхойлох, цалинг инфляцын түвшинтэй | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шийдвэрийг гаргуулах;<br>- Бодлогын баримт бичиг, эрх зүйн баримт бичигт тусгахад нөлөөлөх, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх;<br>- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 155, 182 дугаар конвенцын хэрэгжилтийн талаар судалгаа хийх. | | | | | уялдуулан үе шаттай нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг МУЗГ-т даалгасан.<br>2. Комиссын дарга Д.Сүнжид 2023.10.25, 26-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын хүний эрхийн сургагч багшийн сургалтаар “ШШГБ-ын алба хаагчдын хөдөлмөрлөх эрх” сэдвээр хичээл зааж, нөлөөллийн ажлуудыг явуулсан.<br>3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 155, 182 дугаар конвенцын хэрэгжилтийн талаар судалгаа хийх ажил Комиссын хурлын шийдвэрээр 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс хассан болно. | |
| 2.1.5 | Арга хэмжээ 2.1.5: Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн чиглэлээр хийх судалгааны бэлтгэл хангах.<br>- Ховд, Сүхбаатар, Өмнөговь, Сэлэнгэ, Орхон аймагт судалгаа хийх бэлтгэл хангах. | Төсөл, хөтөлбөр | Судалгааны ажлын бэлтгэл хангах үйл ажиллагааны хувь | 0 | 100 | Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн асуудлаар Комиссын гишүүн С.Дондовоор ахлуулсан ажлын хэсэг Ховд аймгийн Дарви суманд 2023.06.12-19, Комиссын гишүүн Д.Сүнжидээр ахлуулсан ажлын хэсэг 2023.08.23-29-ний өдрүүдэд Дорнод аймагт тус тус хяналт шалгалт, мониторинг хийв. “Петрочайна дачин тамсаг” ХХК-д хийсэн хяналт шалгалтын хүрээнд Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяад хуулийн хэрэгжилт хангуулж ажиллах чиглэлээр Комиссын гишүүн Д.Сүнжид 2023.10.18-ний өдөр 05/56 дугаартай Зөвлөмж, “Петрочайна дачин тамсаг” ХХК-д ажиллаж буй албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 2023.10.24-ний өдөр 05/27 дугаартай Шаардлагыг тус тус хүргүүлсэн. Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтэд хийсэн мониторингийн тайлан, шинжээчийн дүгнэлтийг Ханнс-Зайделийн санд хүргүүлсэн. | 100 |
| 2.1.6 | Арга хэмжээ 2.1.6: Нийслэлийн ЗДТГ, холбогдох байгууллага, шинжээчидтэй хамтран Улаанбаатар хотод хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд ноцтой эрсдэл хохирол учруулж болзошгүй барилга байгууламж, зам, гарц, гэрлэн дохио, гэрэлтүүлэг, хүнс, хүүхдийн тоглоомын газар, нуур цөөрөмд үзлэг хийж, эрсдэлтэй объектуудын жагсаалтыг гаргуулах, аюулгүй болгох ажлыг үе шаттай явуулахад нөлөөлөх. | Улсын төсөв | Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | Комиссын гишүүн Б.Энхболд, Х.Мөнхзул нар 2023.06.15 өдөр НЗДТГ, Нийслэлийн хотын Стандарт, хяналтын газар, Хот байгуулалтын хөгжлийн газар, Орон сууцны бодлогын газар, Нийслэлийн Замын хөгжлийн газар, Газар зохион байгуулалтын алба, Байгаль орчны газар, Замын хөдөлгөөний удирдлагын төвийн удирдлага, холбогдох албан тушаалтнуудтай уулзаж, нийслэл хотод хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой эрсдэл, хохирол учруулж болзошгүй нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, хүний эрхийн хэрэгжилтийг хангуулах асуудлаар хамтарсан уулзалт хийсэн. Уулзалтын үр дүнд Хотын стандарт, хяналтын газраас эрсдэлтэй объектуудын судалгааг гаргуулан авч, судалгаанд дурдагдсан нөхцөл байдлыг арилгах чиглэлээр Нийслэлийн 6 дүүргийн Засаг даргын зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээллийг гаргуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | - Нөлөөллийн ажлыг эхлүүлэх /Олон нийтээс мэдээлэл цуглуулах/ | | | | | Мөн 2023.10.24-ний өдөр Барилгын хөгжлийн төвийн Зураг төслийн хяналтын газрын дарга Д.Чинзолбоо, Барилга байгууламжийн зураг төсөл магадлалын хэлтсийн дарга Э.Хангал нартай уулзаж, барилгын зөвшөөрөл хэрхэн олгогдож байгаа болон холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилт, тулгарч байгаа саад бэрхшээл, цаашид авах арга хэмжээний талаар санал солилцсон. Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтийн талаар тусгайлсан судалгааны ажлыг судлаач Р.Мөнхзул, П.Баттулга нараар гүйцэтгүүлж, үр дүнг Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлд тусгахаар ажиллаж байна. | |
| МУХЭҮКТХ: 7.1.9.жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих; | | | | | | | |
| 2.1.7 | Арга хэмжээ 2.1.7: “Шийдвэр гаргах түвшинд жендерийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх. | КОИКА ОУБ, НҮБХХ-ийн санхүүжилтээр | Төслийн хэрэгжилтийн хувь | 50 | 75 | "Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь" төслийн 2023 оны төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийсэн байна.Үүнд:<br>- Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн 7 дугаар бүлгийг “Улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдал” сэдвээр боловсруулав.<br>- “Улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдлын хэрэгжилтийг үнэлэх судалгаа”-ны тайланг 1000 хувь хэвлүүлэн олон нийтэд түгээхийн зэрэгцээ Комтссыг цахим хуудас, цахим номын санд байршуулав.<br>- Нийслэл, 9 дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид болон улс төрийн намын төлөөлөлд “Улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдал” илтгэлийг танилцуулах, санал солилцох уулзалт, хэлэлцүүлгийг 2023.01.17-ны өдөр зохион байгуулсан.<br>Шалгаруулалтыг 3 үе шаттай зохион байгуулж НИТХ-аас 1, аймаг, дүүргийн ИТХ-аас 30, нийт 31 жендэрийн мэдрэмжтэй эрэгтэй манлайлагч тодров. Шалгарсан 31 манлайлагчийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор 2 шторк 36 постерыг хийж Комиссын цахим хуудас болон фэйсбүүк хуудас, 21 аймаг, Нийслэл, дүүргүүдийн албан ёсны болон бусад олон нийтийн цахим хуудсаар түгээв.<br>ХЭҮК-ын хэрэгжүүлсэн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг КОЙКА ОУБ, НҮБХХ-ийн “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн үнэлгээний багт хүлээлгэн өгсөн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.8 | Арга хэмжээ 2.1.8: “Иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх. | НҮБХХ-ийн санхүүжилтээр | Төслийн хэрэгжилтийн хувь | 75 | 100 | Төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу Хэнтий, Архангай аймагт тухайн аймгийн сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нар, аймгийн төрийн байгууллагуудын удирдах албан тушаалтан зэрэг нийт 194 хүн “Жендэр ба Хүний эрх” сургалтад хамрагдаж, Хэнтий аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Архангай аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Стандарт, хэмжил зүйн хэлтэс, аймгийн Засаг даргын Тамгын газарт Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт хийлээ. Төсөл хэрэгжих хугацаанд бэлтгэгдсэн сургагч багш нараас төслийн үр дүнгийн талаар тандалт судалгаа авч “Сургагч багш”-аар бэлтгэдсэний ач холбогдол, үр дүн, гарсан эерэг өөрчлөлт, зохион байгуулсан сургалтын тоо, оролцогчдын тоо, хэлбэр, хүндрэл бэрхшээл зэргийг тодруулж, улмаар цаашид бэлтгэгдсэн багш нарыг давтан сургах, үйл ажиллагааг нь эрчимжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх, хэрэгцээг тодорхойлов.<br>“Иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийг хэрэгжүүлэх хүрээнд дараах 3 хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>1. 2023.04.18-ны өдөр Архангай аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтэст,<br>2. 2023.04.19-ны өдөр Архангай аймгийн Засаг даргын Тамгын газарт,<br>3. 2023.04.19-ны өдөр Архангай аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт.<br>Төслийн 3 дахь үр дүнгийн хүрээнд 2023 онд зохион байгуулсан үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрт хүргүүлсэн байна. | 100 |
| 2.1.9 | Арга хэмжээ 2.1.9: Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сантай хамтарсан төслийг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх. | НҮБХАС-ийн санхүүжилтээр | Төслийн хэрэгжилтийн хувь | 75 | 100 | 1. НҮБХАС-ийн 2023.05.22-ны өдөр Ази, номхон далайн бүсийн газраас Тайландын Вант Улсын Бангкок хотноо зохион байгуулсан “Хүний эрхийн семинар”-т СДШХШХ-ийн ахлах референт Ч.Ариунаа оролцож батламж авсан.<br>2. НҮБХАС-тай хамтран хийсэн "Их, дээд сургуулийн оюутан залуусын бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн хэрэгжилт судалгааны тайлан"-г Комиссын цахим номын сан, цахим хуудсаар сурталчилж байна.<br>3. Комиссоос 2023 оны 9-10 дугаар сард зохион байгуулсан “Ажлын байрны бэлгийн дарамт” аян, Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан “Хүний эрхийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Үндэсний Форум-2023” арга хэмжээнд НҮБ-ын Хүн амын сан санхүүгийн дэмжлэг үзүүлж ажилласан.<br>Комиссоос НҮБ-ын ХАС-тай 2024 онд нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн асуудлаар нөлөөллийн ажлыг хийхээр төлөвлөж байна. | |
| МУХЭҮКТХ:7.1.11.Төрийн байгууллага, албан тушаалтан хүний эрхийг хангах, хамгаалах, хүндэтгэх үүргийн хэрэгжилтэд ХЭҮКТХ болон бусад хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд хяналт тавих. | | | | | | | |
| 2.1.11 | Арга хэмжээ 2.1.11: Гомдол, мэдээллийн мөрөөр хяналт шалгалт хийх. | Улсын төсөв | Хяналт, шалгалтын үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 100 | 100 | Тайлант хугацаанд гомдлын мөрөөр 28 хяналт шалгалт хийв. Үүнд:<br>1. 2023.02.03-ны өдөр Сүхбаатар аймгийн “Энэрэл ачтан” Өрхийн эрүүл мэндийн төвд,<br>2. 2023.02.06-ны өдөр Дархан-Уул аймаг дахь Давж заалдах болон Захиргааны хэргийн шүүхийн Тамгын газарт,<br>3. 2023.02.07-ны өдөр Сэлэнгэ аймгийн Хушаат сумын Засаг даргын Тамгын газарт,<br>4. 2023.02.08-ны өдөр Багахангай дүүргийн 207 дугаар цэцэрлэгт,<br>5. 2023.03.28-ны өдөр Өмнөговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Цагдан хорих байранд,<br>6. 2023.04.10-ны өдөр Хэнтий аймгийн Баян-Адарга сумын Эрүүл мэндийн төвд,<br>7. 2023.04.12-ны өдөр Баян-Өлгий аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд,<br>8. 2023.04.19-ний өдөр Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуульд,<br>9. 2023.05.09-ний өдөр Санхүү, эдийн засгийн их сургуулийн Инновац хөгжлийн газарт,<br>10. 2023.05.16-ны өдөр Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-т<br>11. 2023.05.17, 18-ны өдөр Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Ерөнхий боловсролын “Нутгийн аваргууд” сургуульд<br>12. 2023.05.18-ны өдөр Монголын Үндэсний Их сургуульд<br>13. 2023.05.24-ний өдөр Завхан аймгийн Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуульд,<br>14. 2023.05.25-ны өдөр Сэлэнгэ аймгийн Шуудан үйлчилгээний газарт,<br>15. 2023.05.26-ны өдөр Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуульд,<br>16. 2023.05.29-ний өдөр Завхан аймгийн Улиастай сумын Жавхлант цогцолбор сургуульд,<br>17. 2023.06.12-ны өдөр Иргэний нисэхийн ерөнхий газарт, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 18. 2023.08.18-ны өдөр Дотоод хэргийн их сургуулийн Сургалт бэлтгэлийн төвд,<br>19. 2023.10.05-ны өдөр Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газарт,<br>20. 2023.10.17-ны өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь 413 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид, 21. 2023.10.25-ны өдөр Ерөнхий боловсролын “Эм Ай Юу” дунд сургуульд,<br>22. 2023.11.14-ний өдөр Зэвсэгт хүчний 326 дугаар ангид,<br>23. 2023.11.15-ны өдөр Сэлэнгэ аймгийн Баянгол сумын ЕБС-д,<br>24. 2023.11.15-ны өдөр Цемент-Шохой ТӨХК-д,<br>25. 2023.11.16-ны өдөр Эрдэнэт хивс ХХК-д,<br>26.2023.11.16-ны өдөр Эрдэнэт булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-д,<br>27. 2023.11.17-ны өдөр Орхон аймгийн Ирээдүйн одод ЕБС-д,<br>28. 2023.11.30-ны өдөр Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн Дотуур байранд. | |
| 2.1.12 | Арга хэмжээ 2.1.12: Комиссын дарга, гишүүний санаачилгаар хүний эрхийн хяналт шалгалт хийх.<br>- 29 дүгээр тусгай сургуульд;<br>- 116 дугаар тусгай сургуульд;<br>- Хагас өнчин, бүтэн өнчин хүүхдийн эрхийг хамгаалах төрийн байгууллагуудад;<br>- Хүүхдийн эрхийн хууль зүйн хороод /9 дүүрэг, Архангай, Говьсүмбэр, Дорноговь, Хэнтий/;<br>- Оюу Толгой ХХК болон нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаанд;<br>- Эрүүл мэндийн яамны дэргэдэх зөвлөл, комиссын үйл ажиллагаанд;<br>- Цэргийн алба хаагч, оюутан, сонсогчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд шинжээчдийн оролцоотой хяналт шалгалт хийж, зөвлөмж гаргах;<br>- Сургуулийн орчны аюулгүй байдлын хэрэгжилтэд түүвэр | Улсын төсөв | Хяналт, шалгалтын үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 100 | 100 | Тайлант хугацаанд Комиссын дарга, гишүүний санаачилгаар нийт 117 хяналт шалгалтыг гүйцэтгэсэн ба төлөвлөгөөнд тусгагдсан дараах хяналт шалгалтуудыг хийсэн. Үүнд:<br>- Нийслэлийн ерөнхий боловсролын 74, 29, 116 дугаар сургуульд,<br>- Хүүхдийн эрхийн хууль зүйн хороод /Архангай, Говьсүмбэр, Дорноговь, Хэнтий, Нийслэлийн Чингэлтэй, Сүхбаатар, Багануур, Налайх дүүрэг/,<br>- “Оюу Толгой” ХХК болон нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаанд,<br>- Эрүүл мэндийн яамны дэргэдэх зөвлөл, комиссын үйл ажиллагаанд,<br>- Соёл Урлагийн Их Сургуульд. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хяналт шалгалт хийх;<br>- УБТЗ ХНН-ийн хөдөлмөрийн хүрээний дарамт, шахалтын асуудлаар хяналт шалгалт хийх;<br>- Соёл Урлагийн Их Сургуульд;<br>- “Төрийн үйлчилгээ ба хүний эрх” асуудлаар боловсролын салбарт. | | | | | | |
| МУХЭҮКТХ:26.1.1. Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн, зөрчих нөхцөл бүрдүүлсэн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд шаардлага, зөвлөмж хүргүүлэх; | | | | | | | |
| 2.1.13 | Арга хэмжээ 2.1.13: Комиссын гишүүний шаардлага хүргүүлэх. | Улсын төсөв | Шаардлага боловсруулах ажлын гүйцэтгэлийн хувь | 100 | 100 | Комиссын гишүүд гомдлын мөрөөр 11, хяналт шалгалтын мөрөөр 14, дүн шинжилгээний мөрөөр 1 нийт 26 шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн. Үүнд:<br>**Гомдлын мөрөөр:**<br>1. Комиссын гишүүн Г.Нарантуяагийн Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбатад 2023.01.27-ны өдөр хүргүүлсэн “Монгол Улсын Их хурлын 2020 оны ээлжит сонгууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын эцсийн тайланг маягтуудын дагуу Бодлогод залуусын хяналт НҮТББ-д бүрэн гүйцэд өгөх тухай” 04/06 дугаар Шаардлага;<br>2. Комиссын гишүүн Б.Энхболдын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа О.Амарсанаад 2023.03.07-ны өдөр хүргүүлсэн “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2018 оны А/69 дүгээр тушаалаар батлагдсан Хоригдлын тоо бүртгэл хөтлөх зааврын 2 дугаар хэсгийн 4.1-д “хэрэв хугацааны төгсгөл ажлын бус өдөр тохиолдвол хугацааны сүүлийн өдрийг түүний дараагийн ажлын эхний өдрөөр тоолно” гэж заасныг хүчингүй болгож, хүний эрхийн зарчимд нийцүүлэх тухай” 06/07 дугаар Шаардлага;<br>3. Комиссын гишүүн Г.Нарантуяагийн НИТХ-ын дарга Ж.Батбаясгаланд 2023.04.27-ны өдөр хүргүүлсэн “Шашны үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад шинээр зөвшөөрөл олгохыг хүчин төгөлдөр үйлчилж буй Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль, холбогдох журмын хүрээнд сэргээн явуулах, гомдол гаргагч байгууллагуудын гаргасан хүсэлтийг хянаж шийдвэрлэх тухай” 04/09 дүгээр Шаардлага;<br>4. Гомдлын мөрөөр Комиссын дарга Ж.Хунангийн 2023.06.16-ны өдөр Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Ж.Наранболдод хүргүүлсэн “иргэн А.Буянхишигтийн төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх хууль ёсны ашиг сонирхлыг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөрчихгүй байх, ажлын байр, ажиллах нөхцөл, боломжоор хангах тухай” 01/13 дугаар Шаардлага;<br>5. Комиссын гишүүн Г.Нарантуяагийн Номин реалтор ХХК-ийн гүйцэтгэх захирал И.Галбуянд 2023.08.14-ний өдөр хүргүүлсэн “Нэр бүхий иргэдийн зохистой орон байраар хангагдах эрхийг эдлүүлэх, өмчлөх эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” 04/15 дугаар Шаардлага;<br>6. Комиссын гишүүн Д.Сүнжидийн Баян-Өлгий аймгийн Засаг дарга А.Камелиятад 2023.09.18-ны өдөр хүргүүлсэн “Баян-Өлгий аймгийн Барилга захиалагчийн албаны Барилгын хяналтын инженер С.Ержан, жолооч Ө.Берген нарын хөдөлмөрлөх эрхийг хангах, ажилгүй байх хугацааны нийгмийн даатгалыг нөхөн төлөх тухай” 05/19 дүгээр Шаардлага;<br>7. Комиссын дарга Ж.Хунангийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Р.Онончимэгт 2023.11.03-ны өдөр хүргүүлсэн “Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016.12.14-ний өдрийн 102/ШШ2016/06056 дугаартай шийдвэрийг Шүүхийн цахим сангаас устгах тухай” 01/23 дугаар Шаардлага;<br>8. Комиссын гишүүн Д.Сүнжидийн Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатарт 2023.11.09-ний өдөр хүргүүлсэн “Сурагчдын сурч боловсрох эрх зөрчигдөж болзошгүй аливаа үйл ажиллагааг таслан зогсоох, сургалтын үйл ажиллагааг үндэслэлгүйгээр тасалдуулахгүй байх тухай” 05/26 дугаар Шаардлага;<br>9. Комиссын гишүүн Г.Нарантуяагийн Сайн интернэшнл ХХК-ийн захирал Т.Ган-Очирт 2023.05.02-ны өдөр хүргүүлсэн “Хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах дотоод журам баталж мөрдүүлэх тухай” №04/11 дүгээр Шаардлага;<br>10. Комиссын гишүүн Г.Нарантуяагийн Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн харьяа Ерөнхий боловсролын сургуулийн захирал М.Мөнхбаатарт 2023.10.23-ны өдөр хүргүүлсэн “Фэйсбүүк зурвасаар дамжуулан суралцагчдаас цуглуулсан хувийн мэдээллийг устгах тухай” 04/20 дугаар Шаардлага;<br>11. Комиссын гишүүн Г.Нарантуяагийн “Тус финтек ББСБ” ХХК-ийн гүйцэтгэх захирал М.Гантулгад 2023.11.08-ны өдөр хүргүүлсэн “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль зөрчсөн ажилтанд уг хуулийг чанд мөрдөх сануулга өгөх тухай” 04/25 дугаар Шаардлага;<br>**Хяналт шалгалтын мөрөөр:**<br>1. Комиссын гишүүн Х.Мөнхзулын Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг дарга А.Сүхболдод 2023.05.01-ний өдөр | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүргүүлсэн “Тус дүүргийн 207 дугаар цэцэрлэгт хийсэн хяналт шалгалтаар илэрсэн хөдөлмөрлөх эрхийн зөрчлийг таслан зогсоох тухай” 03/10 дугаар Шаардлага;<br>2. Комиссын гишүүн Х.Мөнхзулын Санхүү, эдийн засгийн их сургуулийн ректор Б.Мөнхбаярт 2023.06.28-ны өдөр хүргүүлсэн “СЭЗИС-ийн Инновац, хөгжлийн газарт ажлын байрны бэлгийн дарамтаас ангид байх эрхийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтаар ирсэн зөрчлийг арилгуулах тухай” 03/14 дүгээр Шаардлага;<br>3. Комиссын гишүүн Х.Мөнхзулын Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Р.Онончимэгт 2023.08.17-ны өдөр хүргүүлсэн “Дархан-Уул аймаг дахь Давж заалдах шатны болон Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газарт ажлын байрны дарамтаас ангид байх эрхийн хэрэгжилтэд хийсэн хийсэн хяналт шалгалтаар ирсэн зөрчлийг арилгуулах тухай” 03/16 дугаар Шаардлага;<br>4. Комиссын гишүүн Д.Сүнжидийн Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогтод 2023.09.07-ны өдрийн хүргүүлсэн “Иргэний нисэхийн ерөнхий газарт ажлын байрны дарамтаас ангид байх эрхийн хэрэгжилтэд хийсэн хийсэн хяналт шалгалтаар ирсэн зөрчлийг арилгуулах тухай” 05/17 дугаар Шаардлага;<br>5. Комиссын гишүүн Б.Энхболдын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, бригадын генерал О.Амарсанаад 2023.11.01-ний өдөр хүргүүлсэн “Тусгай ажиллагааны газрын алба хаагчид нь 413 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид ажиллахдаа нийт хоригдлуудтай хүнлэг бус харьцсан байх тул холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох тухай” 06/22 дугаар Шаардлага;<br>6. Комиссын гишүүн Х.Мөнхзулын Багахангай дүүргийн Засаг дарга А.Сүхболдод 2023.11.08-ны өдөр хүргүүлсэн “Баганхангай дүүргийн ЗДТГ-ын ажилтан, албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах тухай” 03/24 дүгээр Шаардлага;<br>7. Комиссын гишүүн Б.Энхболдын Булган аймгийн Засаг дарга Б.Ариун-Эрдэнэд 2023.01.03-ны өдөр хүргүүлсэн “Булган аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Ахмадын сан, Булган сумын ЕБС-ийн дотуур байранд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг таслан зогсоох тухай” 06/01 дүгээр Шаардлага; | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 8. Комиссын гишүүн Б.Энхболдын Орхон аймгийн Засаг дарга С.Батжаргалд 2023.01.06-ны өдөр хүргүүлсэн “Орхон аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Ахмадын санд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг таслан зогсоох тухай” 06/03 дугаар Шаардлага;<br>9. Комиссын гишүүн Б.Энхболдын Дархан-Уул аймгийн Засаг дарга Б.Азжаргалд 2023.01.24-ний өдөр хүргүүлсэн “Дархан-Уул аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Ахмадын сан, Нарны хүүхдүүд асрамжийн төв, Оюуны ирээдүй цогцолбор сургуулийн дотуур байранд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг таслан зогсоох тухай” 06/04 дүгээр Шаардлага;<br>10. Комиссын гишүүн Б.Энхболдын Орхон аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн захирал Ц.Наран-Эрдэнэд 2023.01.16-ны өдөр хүргүүлсэн “Орхон аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд хийсэн хөдөлмөрлөх эрхийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах тухай” 06/02 дугээр Шаардлага;<br>11. Комиссын гишүүн Б.Энхболдын Дархан-Уул аймгийн “Оюуны ирээдүй” цогцолбор сургуулийн захирал Б.Нарантуяад 2023.01.24-ний өдөр хүргүүлсэн ““Оюуны ирээдүй” цогцолбор сургуулийн дотуур байранд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн хүүхдийн эрхийн зөрчлийг таслан зогсоох тухай” 06/05 дугээр Шаардлага;<br>12. Комиссын гишүүн Г.Нарантуяагийн Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн захирал С.Батмягмарт 2023.04.06-ны өдөр хүргүүлсэн “Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуульд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн хүүхдийн эрхийн зөрчлийн тухай” 04/08 дугаар Шаардлага;<br>13. Комиссын гишүүн Г.Нарантуяагийн Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн захирал Э.Нүрзэдэд 2023.05.12-ны өдөр хүргүүлсэн “Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуульд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн хүүхдийн эрхийн зөрчлийн тухай” 04/12 дугаар Шаардлага;<br>14. Комиссын гишүүн С.Дондовын “МОЭНКО” ХХК-ийн дэд захирал Ж.Оюунчимэгт 2023.11.23-ны өдөр хүргүүлсэн “МОЭНКО ХХК-ийн Хөшөөтийн уурхайд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн хөдөлмөрлөх эрхийн зөрчлийг арилгах тухай” 07/27 дугаар Шаардлага;<br>**Дүн шинжилгээний мөрөөр:** | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1. Комиссын гишүүн Д.Сүнжидийн “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн ерөнхийлөгч Жу Да Лид 2023.10.24-ны өдөр хүргүүлсэн “Компанийн хөдөлмөрийн дотоод журам, бусад дотоод хэм хэмжээ, хөдөлмөрийн гэрээг шинэчлэн баталж мөрдүүлэх, Хөдөлмөрийн тухай хуулийг чанд мөрдөж ажиллах тухай” 05/21 дүгээр Шаардлага; | |
| 3.1.3 | Арга хэмжээ 3.1.3: Гадаадад оршин сууж, сурч, ажиллаж байгаа иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үр дүнтэй, байнгын ажиллагаатай тогтолцоо болгоход Засгийн газар, Гадаад хэргийн яамны санаачлагыг дэмжиж, зөвлөн туслах.<br>- Гадаадад улсад сурч, оршин сууж байгаа Монгол Улсын иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн орчныг сайжруулах санал боловсруулах;<br>- Гадаадад улсад сурч, оршин сууж байгаа Монгол Улсын иргэдийн эрх, эрх чөлөөний хэрэгжилтийн судалгааг эхлүүлэх;<br>- Монгол Улсаас гадаад Улсад суугаа Элчин сайдын яам, Дипломат төлөөлөгчийн газрын | Улсын төсөв | Санал боловсруулах Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 1. Комиссын дарга Ж.Хунан 2023 оны 01 дүгээр сард Турк Улсад, 03 дугаар сард Швейцарийн Холбооны Улсад, 06 дугаар сард Тайландын Вант Улсад хийсэн гадаад томилолтын хүрээнд тус улсуудад оршин сууж буй монгол иргэдтэй уулзалт зохион байгуулж, нөхцөл байдалтай танилцсан бөгөөд Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын удирдамжийн дагуу 2023.03.13-ны өдөр Комиссын дарга Ж.Хунан, гишүүн С.Дондов, Төв аймаг дахь референт У.Чойжилсүрэн нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Монгол Улсаас Швейцарын Холбооны Улсад суугаа Элчин сайдын яаманд хяналт шалгалт хийсэн.<br>2. Гадаад харилцааны яамнаас хийсэн “Хилийн чанадад суугаа Монгол иргэдийн нөхцөл байдлын дүн шинжилгээ” судалгааны ажил, Комиссын төлөвлөсөн зарим үйл ажиллагаатай давхцаж байгаа тул “Гадаадад улсад сурч, оршин сууж байгаа Монгол Улсын иргэдийн эрх, эрх чөлөөний хэрэгжилтийн судалгаа”-ны ажлыг 2023 оны төлөвлөлтөөс хассан болно.<br>3. Ази, Номхон далайн бүс нутгийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын Чуулган (АНДЧ)-ны ээлжит 28 дугаар хуралд Комиссын дарга, Комиссын Тамгын газрын дарга, ХЭССХ-ийн дарга нар 2023.09.20, 21-ний өдрүүдэд оролцох үеэр Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суугаа ЭСЯ-ны ажилтнуудтай уулзалт хийж, Энэтхэг Улсад буддын гүн ухааны чиглэлээр сурч буй хүүхдүүдийн сурч боловсрох, амьдрах, хөгжих, хамгаалуулах | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажилтнуудад хүний эрхийн сургалт зохион байгуулах. | | | | | эрхийн хэрэгжилтийн байдалтай танилцаж үр дүнг Комиссын 2023 оны 10 дугаар сарын хуралдаан болон Улсын Их Хурлын даргад танилцуулав. | |
| 3.1.4 | Арга хэмжээ 3.1.4: Үйлдвэрчний эвлэлд эвлэлдэн нэгдэх эрхийн нөхцөл байдлыг судалж, ажиллагсадын эрх ашгийг хамгаалах тогтолцоог бэхжүүлэхэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх. | Төсөл хөтөлбөр | Холбогдох байгууллагатай хамтарч ажилласан ажлын хэрэгжилтийн хувь | 0 | 100 | Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, хуулийн үзэл баримтлалыг боловсруулах үүрэг бүхий дэд ажлын хэсэг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/182 дугаар тушаалаар байгуулагдсан. 2023.02.15-ны өдөр ҮЭ-ийн эрхийн тухай хуулийг шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайланг танилцуулах уулзалтад Комиссын төлөөлөл оролцож санал солилцон, дэмжлэг үзүүлж ажилласан. Тус ажлын хэсэг дахин хуралдаагүй болно. | 100 |
| 3.1.5 | Арга хэмжээ 3.1.5: Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын эздээс хүний эрхийн хангах, хамгаалах, дэмжих талаар гаргасан санаачлагыг дэмжиж, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх. Хүүхдийн эрхийн асуудлаар Адмон групптэй дараах ажлуудыг хамтран хийнэ:<br>- Хүүхдийн эрхийн тухай конвенцын агуулгаар комикс, цуврал ном бүтээх, ХЭТТ-ийн хүүхдэд зориулсан хялбаршуулсан ном хэвлэх;<br>- Хүний эрхийн олон улсын өдөр фото зургийн үзэсгэлэн зохион байгуулах. | Улсын төсөв | Бизнес ба хүний эрхийн зарчмыг мөрдөхөд хамтарч ажилласан үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 1. Хүүхдийн эрхийн тухай конвенцын агуулгаар 4 цуврал комик ном бүтээх ажлын хүрээнд номын зохиол, зураг, эх бэлтгэх ажлыг хариуцан гүйцэтгүүлэхээр Монгол хэл бичиг, соёл, судлалын олон улсын академийн зохиолч Б.Төрмөнхтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулан хамтран ажилласан. Комикс номын зохиолыг 2023.05.15-ны өдөр эцэслэж, зургийн ажил хийгдэж, гүйцэтгэгч талаас 2023.12.22-ны өдөр 4 цувралын хэвлэлтэд зориулсан хувийг хүлээн авсан.<br>2. Хүний эрхийн тухай тунхаглалыг Ерөнхий боловсролын 1-2 дугаар ангийн сурагчдад зориулан хялбаршуулсан хэлбэрээр хүргэх номын агуулгыг боловсруулсан. ХЭТТ-ийн хүүхдэд зориулсан 32 нүүр бүхий номын эхийг бэлтгэн BCI хэвлэлийн үйлдвэрээр 1500 ширхэгийг хэвлүүлэн олон нийтэд түгээж байна. Мөн номын цахим хувилбарыг Комиссын фэйж хуудсанд байршуулан олон нийтэд түгээн ажилласан. Комиссын пэйж хуудаснаас 34,250 хүнд хүрсэн. Isee.mn, ikon.mn, news.mn, ubn.mn, tur.mn, tug.mn зэрэг 25 цахим сайт хялбаршуулсан номын мэдээллийг нийтэлж, олон нийтэд сурталчилсан.<br>3. Хүний эрхийн олон улсын өдөр фото зургийн үзэсгэлэн гаргах зорилгоор сонирхогчдын фото зургийн уралдааны удирдамжийг олон нийтэд нээлттэйгээр Комиссын цахим хуудас, фейсбүүк хуудсанд байршуулсан. Уралдааны бүтээлийг 2023.10.01-ний өдрийг хүртэл хүлээн авахаар төлөвлөн тухай бүр идэвхжүүлэлт хийсэн боловч уралдаанд тайлант хугацаанд бүтээл ирээгүй болно. Мөн мэргэжлийн гэрэл зурагчидтай гэрээлэн гэрэл зургийн сан үүсгэх ажлын гэрээний төсөл болон танилцуулга | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бэлтгэн 3 мэргэжлийн гэрэл зурагчинтай гэрээлэн гүйцэтгэхээр төлөвлөсөн боловч санхүүжилт байхгүй тул зогссон. | |
| 3.1.6 | Арга хэмжээ 3.1.6: Хүүхэд хамгааллын тогтолцооны үр нөлөө, мэргэжлийн байдлыг (Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, Хүүхдийн эрх хамгааллын салбар дундын байнгын ажлын хэсэг) хангуулахад дэмжлэг үзүүлэх. | Улсын төсөв | Хүргүүлсэн санал, зөвлөмжийн тоо | 0 | 1 | Хүүхдийн эрх хамгааллын салбар дундын байнгын ажлын хэсгийн хуралд тухай бүр нь оролцож, төлөвлөгөөний төсөлд Комиссын санал тусгаж ажилласан. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн ажлын хэсэг, дэд ажлын хэсэгт Комиссын төлөөлөл ажилласан. 2023.04.12, 13-ны өдрүүдэд Нийслэлийн Сонгинохайрхан, Хан-Уул, Баянзүрх, Налайх дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, Хүүхдийн төв сувиллын үйл ажиллагаанд ХНХЯ, ЗГХЭГ-ын дэргэдэх ХЭХҮХ-ны алжлын албатай хамтран Комисс нээлттэй хяналт шалгалт хийж, үр дүнг Хууль зүйн байнгын хорооноос Хүүхдийн эрх хамгааллын асуудлаар хийсэн хяналтын сонсголд танилцуулав. Мөн Хүүхдийн төв сувилалд амьдарч буй хавсарсан хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 3-16 насны 6 хүүхдэд асран хамгаалах үйлчилгээ үзүүлж буй нөхцөл байдал тогтоогдсон нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж холбогдох арга хэмжээ авах талаар Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдад саналаа танилцуулав. | 100 |
| 3.2 | Зорилт 3.2: Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг бэхжүүлэх | | | | | | |
| 3.2.1 | Арга хэмжээ 3.2.1: Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, хэлтсийг чиг үүргээ бүрэн, тасралтгүй, үр нөлөөтэй, хараат бусаар, хүрэлцэхүйц төсөвтэйгээр эрхлэн явуулахад дэмжлэг үзүүлж, чадавхыг бэхжүүлэх ажлыг олон улсын байгууллагын дэмжлэгтэй зохион байгуулах. | Улсын төсөв | Ажиллах, орчин нөхцөлийг бүрдүүлсэн эсэх | 0 | 1 | 1. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийг нэмэгдүүлэх, холбогдох арга хэмжээг авч 2023 оны Комиссын батлагдсан 4,480.5 сая төгрөгийн төсвөөс 439.9 сая төгрөгийг зарцуулав.<br>2. ЭШУС нэгжийрн ажиллах орчинг сайжруулах зорилгоор өрөөний цонх солих, засвар үйлчилгээ хийх, албан хаагчдын ширээ, сандал, техник хэрэгслийг шинэчилж, подкаст, шууд бичлэгийн төхөөрөмжийг худалдан авав. 2024 оны батлагдсан төсвийн 10 орчим хувийг зарцуулахаар төлөвлөв.<br>3. БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОИКА)-д БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОИКА)-ын зардлаар ЭШУСХэлтсийн нэг албан хаагчийг 1 сарын хугацаатай Япон улсад чадавхжуулах сургалтад хамруулав. Мөн ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн 2023 онд 2023 онд Швейцарийн Холбооны Улс, Дани Улсад олон улсын хурал, уулзалтад оролцов.<br>Мөн БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагад Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизм болон орон нутгийн ажилтнуудыг чадавхжуулах зорилгоор БНСУ-ын ХЭҮК-т | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | туршлага судлах сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх төслийн саналыг хүргүүлсэн. | |
| 3.3 | Зорилт 3.3: Хүний эрх хамгаалагчийг хамгаалах үндэсний механизмыг бэхжүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх. | | | | | | |
| 3.3.1 | Арга хэмжээ 3.3.1: Хүний эрх хамгаалагчийн хорооны гишүүдийг сонгон шалгаруулж, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн хуульч, хүний эрхийн хамгаалагчдаас бүрдсэн Хороо байгуулах. | Улсын төсөв | Шинээр байгуулагдсан хорооны тоо | 0 | 1 | Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5-д заасны дагуу ХЭҮК-ын даргын 2022.06.29-ний өдрийн А/24 дүгээр тушаалаар байгуулагдсан “Хүний эрх хамгаалагчийн хорооны гишүүн сонгон шалгаруулах” ажлын хэсэг нь Хорооны гишүүнийг сонгон шалгаруулах нээлттэй сонсголыг 2022.07.29-ний өдрөөс 2023.02.28-ны өдрийн хооронд 3 удаа зохион байгуулж, ашгийн бус хуулийн этгээдийн төлөөллөөс 4 гишүүн, Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульч болон Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгчдөөс тус бүр нэг төлөөлөл томилогдсоноор Хороо бүрдсэн. Уг Хорооны үйл ажиллагаа жигдэрч, хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч, ажиллагаа хийж байна. Хороо байгуулагдсанаас хойш 5 хүний эрх хамгаалагчийн гомдолд Хорооны гишүүд хоёр, хоёроороо багаар хуваарилагдан ажиллагаа хийн, 4 гомдолд дүгнэлт бичиж, Хорооны хуралдаанаар хэлэлцэн эцэслэж байна. | 100 |
| 3.3.2 | Арга хэмжээ 3.3.2: Хүний эрх Хамгаалагчийн Хорооны хуралдааныг тогтмолжуулах, Хорооны дүгнэлт, хуралдааны тэмдэглэлийг албажуулах | Улсын төсөв | Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | Хүний эрх хамгаалах хороо байгуулагдсанаас хойш нийт 5 удаагийн хуралдааныг зохион байгуулж. Хүний эрх хамгаалагчийн эрхийг хамгаалахтай холбоотой 2 дүгнэлтийг батлан гаргав. | 100 |
| 3.3.3 | Арга хэмжээ 3.3.3: Хүний эрх хамгаалагчийн хорооны гишүүд болон Хүний эрх хамгаалагчийн хэлтсийн ажилтнуудыг хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх ажлыг олон улсын байгууллагын дэмжлэгтэй зохион байгуулах. | Төсөл хөтөлбөр | Хамрагдсан төслийн тоо | 0 | 1-ээс доошгүй | 1. ХЭҮК-ын дэргэдэх орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хорооны үйл ажиллагааг эрчимжүүлэх, хорооны гишүүд болон алба хаагчдыг чадавхжуулах, дүгнэлт гаргах үндсэн чиг үүрэг гүйцэж хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Комиссын дэргэдэх Хүний эрх хамгаалагчийн хороо болон Хүний эрх хамгаалагчийн хэлтэс, орон нутгийн алба хаагчдад зориулсан сургалтыг 2023.04.06-ны өдөр зохион байгуулсан. Тус сургалтаар Хүний эрхийг хамгаалагчийн тухай тунхаглал, Хүний эрх хамгаалагчийг хүлээн зөвшөөрөх, хамгаалах тухай загвар хууль, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг баталсан үйл явц цаашлаад, эрсдэлийн үнэлгээ, аюулын зэрэг тогтоож буй өнөөгийн нөхцөл байдал, хүний эрх хамгаалагчдад хийж буй эрсдэлийн үнэлгээний тухай дотоодын болон олон улсын туршлага, цахим орчинд мэдээллийн аюулгүй байдал хангах, хамгаалах, хүний эрх хамгаалагчтай холбоотой | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гомдол, мэдээлэл хүлээн авах, шийдвэрлэх, ХЭХХ-ны дүгнэлт гаргах ажиллагаа зэрэг олон талт мэдээлэл хийсэн.<br>2. ХЭҮК-ын дэргэдэх орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хорооны гишүүд, Комиссын ХЭХХ-ийн ажилтнууд, ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн алба хаагчид, Хүний эрхийн форумын дэргэдэх Хүний эрхийн зөрчилд шуурхай хариу үзүүлэх тусгай төсвийн гишүүдэд зориулсан “Хүний эрх хамгаалагчийн хорооны үйл ажиллагааг бэхжүүлэх нь” сургалтыг 2023.09.08-ны өдөр зохион байгуулсан.<br>3. Хүний эрх хамгаалагчийг хамгаалах тогтолцоог сурталчлах, олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор “Хүний эрх хамгаалагч” сургалтын модуль боловсруулж байна. Энэ хүрээнд Комиссын дэргэдэх орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хорооны гишүүд болон Комиссын Хүний эрх хамгаалагчийн хэлтэс, орон нутаг дахь албан хаагчид, “Монголын Эмнести интернэшнл”, Монголын эмэгтэйчүүдийн Сан, “ОюуТолгойн хяналт” ТББ-ын төлөөлөлд тус сургалтын модулийн арга зүй, агуулгыг танилцуулж, санал солилцох туршилтын сургалтыг 2023.11.09-ны өдөр зохион байгуулсан.<br>4. “Хүний эрх хамгаалагч” сургалтын модуль турших сургалтаар “Сургалтын модулийн арга зүйн асуудал”, “Хүний эрх хамгаалагчийн ойлголт, тэдэнд тулгарах бэрхшээл, эрсдэлийн үнэлгээ хийх зэрэг сэдвийн онцлог, агуулга”, “Хүний эрх хамгаалагчийг хамгаалах олон улсын болон үндэсний механизм сэдвийн онцлог, агуулга”, “Хүний эрх хамгаалагчийн талаар гаргасан сургалтын модулийн интрактив тестийг турших, түүний зааварчилгаа”-ны талаар оролцогчид хэлэлцэж, санал солилцлоо.<br>5. БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОИКА)-д 2024 онд Хүний эрх хамгаалагчийн хороо, ХЭХХ болон орон нутаг дахь албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор БНСУ-ын ХЭҮК, иргэний нийгэмтэй туршлага судлах сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх төслийн саналыг хүргүүлсэн. | |
| 3.3.4 | Арга хэмжээ 3.3.4: Сонгосон салбарт хүний эрх хамгаалагчийн эрхийн хэрэгжилтэд судалгаа хийх. | Улсын төсөв | Судалгааны ажлын тоо | 0 | 1 | “Иргэний нийгэм дэх хүний эрх хамгаалагчдын эрхийн хэрэгжилт” судалгааг хийж, үр дүнг Монгол Улсын Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлд тусгахаар төлөвлөн ажиллаж байна. | 90 |
| 3.3.5 | Арга хэмжээ 3.3.5: Хүний эрхийн чиглэлээр төслийн санал боловсруулж санхүүжүүлэгч | Улсын төсөв, төсөл хөтөлбөр | Боловсруулсан төслийн тоо | 0 | 3 | 1. ХЭҮК-ын дэргэдэх орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хорооны гишүүд, ХЭХХ-ийн албан хаагчид, ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн алба хаагчдыг чадавхжуулах | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагад хүргүүлэх, дүн шинжилгээ хийх.<br>- Хүний эрх хамгаалагчийг хамгаалах механизмыг бэхжүүлэх төсөл;<br>- Боловсролын хөтөлбөрт хүний эрхийн үүднээс дүн шинжилгээ хийх төсөл;<br>- Урлагаар дамжуулж хүний эрхийн боловсрол олгох төсөл;<br>- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн асуудлаар аян зохион байгуулах төслийн санал боловсруулж, НҮБ-ын Бээжин дэх ЮНЕСКО-д хүргүүлэх;<br>- “Төсөв ба хүний эрх” хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд шаардлагатай төсвийн хуваарилалтад дүн шинжилгээ хийх. | | | | | зорилгоор “Хүний эрх хамгаалагчийг хамгаалах механизмыг бэхжүүлэх нь” 20.000 долларын санхүүжилт хүссэн төслийн саналыг боловсруулж НҮБ-ын ХЭДКГ-т хүргүүлсэн. Улмаар уг төслийг ХЭДКГ-аас 2024 оны 1 дүгээр улирлаас эхлүүлэхээр шийдвэрлэж ажлын зураглал, үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, тогтмол мэдээлэл солилцон ажиллахаар тохиролцсон.<br>2. ХЭХХ, Хүний эрх хамгаалагчийн хорооны гишүүд, ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн алба хаагчдыг чадавхжуулах 5,5 сая төгрийг төсөвтэй сургалтын төслийг боловсруулж Монголын Эмэгтэйчүүдийн санд хандан санхүүжилтийг шийдвэрлүүлж, хамтарсан сургалтыг зохион байгуулсан.<br>3. UNESCO- ийн Бээжин хот дахь Салбарын захирал Shahbaz Khan-тай Залуу судлаачдыг дэмжих сангийн судлаачдын төлөөллийн оролцуулан уулзалт хийж "Хүнлэг Монгол хүн" нөлөөллийн кампанит ажлын талаар болон Хүний эрхийн тайлбар толь гаргах асуудлаар танилцуулга хийсэн.<br>4. Монгол Улсад дахь гадаад улсын ДТГ, ОУБ-ын төлөөллийг оролцуулсан "Тогтвортой хөгжлийн зорилго-Хамтын ажиллагаа" сэдэвт уулзалтыг 2023.11.22-ны өдөр зохион байгуулж Комиссоос хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төслийн саналуудыг танилцуулсан. Үүнд:<br>- "Урлагаар дамжуулж хүний эрхийн боловсрол олгох нь" төсөл;<br>- “Монгол Улсын төсөвт эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн пактаар хүлээсэн үүргийг хэрэгжүүлж байгаа байдалд дүн шинжилгээ хийх аргачлал боловсруулах нь” төсөл;<br>- “Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрхийн хэрэгжилтэд судалгаа, дүн шинжилгээ, хяналт шалгалт, үнэлгээ хийх;<br>- “Орон нутаг дахь иргэний орон зай, иргэний нийгмийн чадавхийг бэхжүүлэх нь” төсөл. | |
| 3.3.6 | Арга хэмжээ 3.3.6: Хуулийн байгууллагын ажилтнуудад хүний эрх хамгаалагчийн тогтолцоог сурталчлах, үйл ажиллагаандаа Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэглээг бий болгоход зориулсан хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулах. | Улсын төсөв, төсөл хөтөлбөр | Зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлгийн тоо | 0 | 1 | 1. Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийг таниулах, сурталчлах ажлын хүрээнд хууль сахиулах байгууллагын алба хаагчид /шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цагдаагийн байгууллага/-ын төлөөлөл, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл, үйлдвэрчний эвлэлийн сонгуульт ажилтан, идэвхтнүүд, сэтгүүлч зэрэг 100 гаруй хүний оролцсон хэлэлцүүлгийг 2023.05.04, 05 өдрүүдэд зохион байгуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.7 | Арга хэмжээ 3.3.7: Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн талаар сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах.<br>- Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хялбарчилсан танилцуулга боловсруулах, түгээх.<br>- Хүний эрх хамгаалагчийн талаар подкаст хийх<br>- Хүний эрх хамгаалагчийн эрхийн хэрэгжилт судалгааны үр дүнг олон нийтэд сурталчлах | Улсын төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 0 | 100 | 1. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хялбаршуулсан товхимол, “хүний эрх хамгаалагчийг хамгаалах тогтолцоо” брошурыг бэлтгэн, 2000 хувь хэвлүүлж олон нийтэд түгээж байна.<br>2. “Хил хязгааргүй алхам” ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан, “Оюу толгойн хяналт” ТББ-ын тэргүүн Д.Сүхгэрэл нартай "Байгаль орчин ба хүний эрх" сэдвээр, “Монголын эмнести интернэшнл” байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн Б.Бадрал, сурагчдын бүлгийн гишүүн Б.Буянзаяа, Түгээмэл хөгжил төвийн Б.Ням-Очир, О.Мөнхзаяа, ХЭҮК-ын орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хорооны гишүүн Э.Сундуй нартай хүний эрх хамгаалагч талаар 6 удаагийн подкаст ярилцлага хийж ХЭҮК-ын фэйсбүүк пэйж хуудас, youtube, soundcloud, castbox, mplus зэрэг сувгаар дамжуулан олон нийтэд түгээж байна. Үүнд:<br>https://youtu.be/Hdtew5MIEcs?si=dK5NXGO_gLtAkFs/<br>https://on.soundcloud.com/gtdtV<br>https://on.soundcloud.com/QfV1H<br>https://on.soundcloud.com/AFXK2<br>https://on.soundcloud.com/et1nW<br>https://on.soundcloud.com/SdDaF<br>3. "Төв тусгал" ТББ-тай хамтран “Хүний эрх хамгаалагчдын мэдлэг ойлголт, хандлага, хэрэгжилт тодорхойлох судалгаа”-г хуульч, өмгөөлөгч, хууль сахиулах байгууллага /шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага/-ын албан хаагчид, сэтгүүлч, хүний эрх хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, байгаль орчны бохирдол, хууль бус уул уурхай, бэлчээрийн доройтлын эсрэг тэмцэж буй малчид, үйлдвэрчний эвлэлийн сонгуульт ажилтан, идэвхтэн, иргэд зэрэг 2,064 хүнийг хамруулан зохион байгуулсан. Судалгааны үр дүнг Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлд тусгасан. Мөн “Хүний эрхийн мэдлэг, ойлголтыг тандах түүвэр судалгаа”-г 18 аймгийн 1812 иргэнийг оролцуулан зохион байгуулж, тайланг боловсруулсан.<br>4. 2023.06.05-19-ний өдрүүдэд Увс, Баян-өлгий, Ховд аймгуудад ажиллахдаа хүний эрх хамгаалагчийг хамгаалах мехнаизмыг сурталчлан таниулах зорилгоор олон нийтэд зориулан кино хэлэлцүүлгийг 6 удаа зохион байгуулж 208 хамруулсан. | 100 |
| 3.4 | Зорилт 3.4: Хүний хувийн мэдээлэл үндэсний механизмыг бэхжүүлэх, чиг үүргийг хэрэгжүүлэх. | | | | | | |
| МУХЭҮКТХ:7.1.10. Хүний хувийн мэдээлэл хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих. | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.4.1 | Арга хэмжээ 3.4.1: Технологи ба хүний эрх, хүний хувийн мэдээлэл хамгаалах асуудлаар олон нийтийн оролцоотой хяналт шалгалтыг эхлүүлж, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах. | Улсын төсөв | Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | Технологи ба хүний эрх, хүний хувийн мэдээлэл хамгаалах асуудлаар олон нийтийн оролцоотой хяналт шалгалтыг 2024 онд эхлүүлэхээр бэлтгэж ажлыг хангаж шаардагдах санхүүжилтийн саналыг хандивлагч байгууллагуудад хүргүүлж байна. Хяналт шалгалтын удирдамжийн төслийг боловсруулж, хяналт шалгалтын үеэр дэмжиж ажиллах үндэсний албан бус сүлжээг байгуулсан. | 10 |
| 3.4.2 | Арга хэмжээ 3.4.2: Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 22.6-д заасны дагуу мэдээлэл хариуцагчийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад илэрсэн зөрчил, түүний сөрөг үр дагаврыг арилгах талаар авсан хариу арга хэмжээний талаар ирүүлсэн бүртгэлийг хүлээн авч хянан, цаашид анхаарах зүйлийн талаар зөвлөмж өгөх. | Улсын төсөв | Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 1. Комиссын гишүүн Г.Нарантуяа ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бөгөөд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга С.Батболдод 2023.04.04-ний өдөр хүний хувийн мэдээллийг хамгаалах буюу RFID технологи суурилуулахтай холбоотой асуудлаар 04/21 дугаар Зөвлөмж хүргүүлсэн болович Зөвлөмжийн хэрэгжилт хангагдаагүй тул 2023.09.19-ны өдөр Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах тухай ТГ- 01/1159 дугаар албан бичиг хүргүүлсэн. Мөн RFID чип хэрэглээнд нэвтрүүлэх шийдвэртэй холбогдуулан зохион байгуулсан хэлэлцүүлгийн бичлэгээр 47 минутын видео контент бүтээж олон нийтэд хүргэсэн.<br>2. Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад илэрсэн зөрчлийн талаар мэдээллийн эзэнд мэдэгдэх, зөрчил, түүний сөрөг үр дагаврыг арилгах талаар авсан хариу арга хэмжээний тухай бүртгэл хөтөлж, бүртгэлийг жил бүрийн нэгдүгээр сард Комисст хүргүүлэх зохицуулалтын дагуу “Дэлхийн зөн” ОУБ, “Монголын самарчдын холбоо”-оос зөрчлийн бүртгэл хүлээн авсан бөгөөд зөвлөмж өгөх нөхцөл тогтоогдоогүй. Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад илэрсэн зөрчлийн талаар авсан хариу арга хэмжээний тухай бүртгэл хөтөлж, бүртгэлийг Комисст ирүүлэхтэй холбоотой зааварчилгаа, видео бичлэгийг Комиссын цахим хуудаст байршуулж, dataprotection@nhrcm.gov.mn цахим хаягаар мэдээллийг хүлээн авч байна. | 100 |
| 3.4.3 | Арга хэмжээ 3.4.3: Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар хүлээсэн Комиссын чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, холбогдох журамд санал өгөх.<br>- Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам;<br>- Хүний хувийн мэдээллийг | Улсын төсөв | Санал хүргүүлсэн журмын тоо | 0 | 4 | 1. Комиссоос 2023.03.14-ний өдрийн “Санал хүргүүлэх тухай” 04/340 тоот албан бичгээр ЦХХХЯ-нд “Цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглахад баримтлах аргачлал, үнэлгээ хийх журам”, “Хүний хувийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үед мэдээллийн аюулгүй байдлыг хангахад үнэлгээ хийх зааварчилгаа”, “Хүний хувийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үед мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хадгалах технологид тавигдах шаардлага", “Хүний эмзэг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | цуглуулах, боловсруулах, ашиглах үед мэдээллийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлагад тусгах мэдээлэл; - Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулахад тавигдах шаардлага, анхааруулгад тусгах мэдээлэл. | | | | | мэдээлэл, биометрик болон генетик мэдээлэл боловсруулахад баримтлах журам, технологийн аюулгүй байдлын шаардлага"-ын төсөлд өгөх саналыг хүргүүлсэн. 2. 2023.02.06-ны өдрийн "Санал хүргүүлэх тухай" 04/168 тоот албан бичгээр ЦХХХЯ-нд "Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулахад тавигдах шаардлага, анхааруулгад тусгах мэдээлэл" журмын төсөл, "Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам", "Хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах үед мэдээллийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлагад тусгах мэдээлэл" журмын төсөлд тусгуулах саналыг хүргүүлсэн. ЦХХХС-ын санал авах тухай албан бичгийн дагуу "Хүний хувийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үед мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хадгалах технологид тавигдах шаардлага", "Хүний хувийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үед мэдээллийн аюулгүй байдлыг хангахад үнэлгээ хийх зааварчилгаа"-ны журмын төсөлд санал хүргүүлсэн. | |
| 3.4.4 | Арга хэмжээ 3.4.4: Хүний хувийн мэдээлэл хамгаалах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудын сүлжээг үүсгэн байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах. | Улсын төсөв | Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 1. Хэрэглэгчийн хувийн мэдээллийг хамгаалах чиглэлээр хамтран ажиллах талаар Худалдаа аж үйлдвэрийн танхим, ШӨХТГ-ын даргатай тус тус уулзалт зохион байгуулсан. 2. 2023.03.13-ны өдөр Харилцаа холбооны зохицуулах хороо дээр ажиллаж, цахим орчинд хүний эрхийг хамгаалах механизм буюу фэйсбүүкийн "ногоон суваг" дахь агуулга, мэдээллийг устгуулахаар ирүүлсэн хүсэлтүүдийг түүвэрлэн судалж, дүн шинжилгээ хийсэн. 3. Хүний хувийн мэдээлэл хамгаалах чиглэлээр ажиллах төрийн болон төрийн бус байгууллагуудын сүлжээний уулзалтад ЦХХХЯ, НҮБХХ, И-Монгол академи, "МХС" ХХК, "Дижитал Информэйшн", "Инфо Сек Плас", "Секьюрзон", "Тридум-эсекьюрити", "Эмнести Интернэшнл" ТББ, "UBCab ХХК", Голомт банк, "MDS Khanlex" ХХН, "Цогц хөгжлийн үндэсний төв" зэрэг хуулийн болон мэдээлэл технологийн салбарын төлөөлөл оролцож, сүлжээнд 22 хүн мэргэжлийн экспертүүд нэгдсэн. | 100 |
| 3.4.5 | Арга хэмжээ 3.4.5: Хүний эрхийн үндэсний байгууллагуудын технологи ба хүний эрхийн сүлжээ, дэлхийн улс орнуудын хувийн мэдээлэл хамгаалах байгууллагуудтай хамтын ажиллагаа хөгжүүлэх. | Улсын төсөв | Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 1. ХМХХ-ийн мэргэжилтэн Б.Болор Хүний эрхийн үндэсний байгууллагуудын технологи ба хүний эрхийн сүлжээ, дэлхийн улс орнуудын хувийн мэдээлэл хамгаалах байгууллагуудтай хамтын ажиллагаа хөгжүүлэх хүрээнд тайлант хугацаанд 3 удаагийн уулзалт, хэлэлцүүлэгт оролцсон. - 2023 оны 02 дугаар сард НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын тэргүүлсэн шинэ Дэлхийн дижитал компакт /UN Global | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Digital Compact/ эвсэлтэй холбоо харилцаа хөгжүүлэх зөвлөлдөх уулзалт,<br>- 2023.06.14-ний өдөр Данийн Хүний эрхийн Хүрээлэнтэй хүний хувийн мэдээлэл хамгаалах, цахим орчинд хүний эрх хамгаалах асуудлаар хамтран ажиллах сүлжээг өргөтгөх уулзалт, хэлэлцүүлэг,<br>- 2023.05.12-ны өдөр ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс, United Nations University-Institute in Macau, UNESCO Beijing Office-оос зохион байгуулсан “Монгол Улс дахь Хиймэл оюун ухааны хэрэглээ” зөвлөлдөх уулзалт.<br>2. Комиссын гишүүн Г.Нарантуяа Австралийн Холбооны Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Нэгдүгээр нарийн бичгийн дарга Дэйв Престон, Австралийн сайн дурын ажилтны хөтөлбөрийн Монгол Улсыг хариуцсан менежер С.Мөнхтуул, Сонгон шалгаруулалт, үйл ажиллагаа хариуцсан ажилтан Т.Отгонбаяр нартай 2023.09.05-ны өдөр уулзаж Комиссын Хүний хувийн мэдээлэл хамгаалах хэлтсийг чадавхжуулах хүрээнд Австралийн Холбооны Улсаас сайн дурын ажилтан сонгон шалгаруулж 6 сараас 1 жилийн хугацаанд ажиллуулах бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>3. Комиссын гишүүн Г.Нарантуяа НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хувийн нууцын асуудал хариуцсан Тусгай илтгэгч доктор Ана Брайан Нугерерс, НҮБ-ын ХЭДКГ-ын Хүний эрх хариуцсан мэргэжилтэн Соня Кронин нартай 2023.09.13-ны өдөр цахимаар уулзаж ХХМХХ-ийг чадавхжуулах, “Технологи ба хүний эрх” нээлттэй хяналт шалгалтыг хийхэд Хувийн нууц хариуцсан Тусгай илтгэгч Ана Брайан Нугерерстэй хамтран ажиллах талаар санал солилцсон. | |
| 3.4.6 | Арга хэмжээ 3.4.6: Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн талаар сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах.<br>- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хялбаршуулсан танилцуулга боловсруулах, түгээх;<br>- Хувийн халдашгүй эрх, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай | Улсын төсөв | Сургалт, сурталчилгааны ажлын гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 1. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн "Бизнес ба хүний эрх" төсөлтэй хамтран Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлэх зорилгоор PWC компаниар дараах ажлуудыг гүйцэтгүүлсэн. Үүнд:<br>- Бизнесийн байгууллагын төлөөлөл (Европын худалдааны танхим, Улаанбаатар худалдааны танхим, МҮХАҮТ, Ноос ноолуурын холбоо, Хүнсчдийн холбоо, Эрдэс баялаг эмэгтэйчүүдийн холбоо, Хэвлэлийн хүрээлэн) болон Комиссын албан хаагч зэрэг нийт 20 хүнийг хамруулсан Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн сургагч багш бэлтгэх сургалтыг 2023.09.26-ны өдөр;<br>- ТАЗ, УДШ, УЕПГ, МБ, ТЕГ, АТГ, ЦЕГ, ЗГХЭГ, Төрийн захиргааны төв байгууллагууд болон тэдгээрийн харьяа | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хуулийн талаар сургалтын хөтөлбөр боловсруулах, видео хичээл бэлтгэж, Комиссын цахим сургалтын талбарт байршуулах. | | | | | агентлагууд зэрэг 28 байгууллагын нийт 32 албан хаагчийг хамруулсан Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн сургагч багш бэлтгэх сургалтыг 2023.10.10-ны өдөр тус тус зохион байгуулсан;<br>- PWC компаниас хоёр төрлийн гарын авлагын төслийг боловсруулж ирүүлсэн бөгөөд хувийн хэвшилд зориулсан гарын авлагыг эцэслэж, төрийн байгууллагад зориулсан гарын авлагыг эцэслэхээр санал боловсруулж байна.<br>- ХХМХтХ-ийн талаарх 5 цуврал бүхий нийт 20 постер бэлтгэн олон нийтэд үе шаттай түгээсэн.<br>- Төрийн байгууллагын сургалтад зориулсан 95 слайд танилцуулга, хувийн хэвшлийн байгууллагын сургалтад зориулсан 85 слайд танилцуулга материалыг тус тус хүлээн авсан.<br>2. Комиссын гишүүн Г.Нарантуяа УИХ-ын даргын ажлын алба, УИХ-ын гишүүдийн ажлын алба, УИХ дахь намын бүлгүүд, УИХТГ-ын 90 гаруй алба хаагчдад “Технологи, хүний хувийн мэдээлэл, хүний эрхийн эрсдэл” сэдвээр сургалт орсон.<br>3. ХХМХХ-т ирсэн гомдол мэдээлэл, агуулгын талаар Eagle, C1 телевизээр Хүний хувийн мэдээлэлтэй холбоотой Комисст ирсэн 26 гомдлын шийдвэрлэлт, авсан арга хэмжээний талаар мэдээлэл өгсөн. | |
| 3.4.7 | Арга хэмжээ 3.4.7: Хүний хувийн мэдээлэл хамгаалах чиглэлээр төслийн санал боловсруулж санхүүжүүлэгч байгууллагад хүргүүлэх.<br>- Хувийн мэдээллийг хамгаалах механизмын чадавхыг бэхжүүлэх;<br>- “Технологи ба хүний эрх”-ийн хүрээнд нээлттэй хяналт шалгалт хийх. | Улсын төсөв | Хүргүүлсэн төслийн саналын тоо | 0 | 1 | Технологи ба хүний эрх, хүний хувийн мэдээлэл хамгаалах асуудлаар олон нийтийн оролцоотой хяналт шалгалт хийх, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах төслийн баримт бичгийг боловсруулж НҮБ-ын ХЭДКГ, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Австрали Улсаас МУ-д суугаа ЭСЯ, НҮБ-ын “Ардчиллыг дэмжих сан”-д, Европын Холбооноос Монгол Улсад суугаа Төлөөлөгчийн газарт тус тус хүргүүлсэн. | 100 |
| Стратегийн зорилго дөрөв. Хүний эрхийн соёл, боловсролын үндэсний тогтолцоог бэхжүүлэх | | | | | | | |
| Алсын хараа 2050: 5.5.2.Бүх нийтэд хүний эрхийн боловсрол олгох үндэсний тогтолцоог бэхжүүлж, хөгжүүлнэ. | | | | | | | |
| МУХЭҮКТХ: 7.1.5.хүний эрхийн боловсролыг дэмжих, түгээх; | | | | | | | |
| 4.1 | Зорилт 4.1: Бүх нийтийн хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх, соёлыг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулах. | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.1 | Арга хэмжээ 4.1.1: Хүний эрхийн онол, эрх зүйн хэм хэмжээ, хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо, олон улсын механизмын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх.<br>- Сургалтын үйл ажиллагааг нэгдсэн тогтолцоонд оруулж, батлагдсан төлөвлөгөөний дагуу сургалтын үйл ажиллагааг явуулах;<br>- УИХТГ-ын ажилтан, гишүүдийн зөвлөхүүдэд сургалт хийх,<br>- Хүний эрхийн хичээл заадаг багш нартай агуулга, арга зүйн хувьд зөвлөлдөх, санал солилцох уулзалт зохион байгуулах;<br>- Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн талаар сургалт зохион байгуулах;<br>- “Жагсаал цуглааны үеэр хэв журам сахиулахад хүний эрхийг хангах нь” сургалтыг төв, орон нутгийн цагдаагийн алба хаагчдад зохион байгуулах;<br>- Сургуулийн орчин аюулгүй байдал сэдвээр сургуулийн нийгмийн ажилтнуудад сургалт зохион байгуулах;<br>- Ажлын байрны дарамт хүчирхийллийн эсрэг сургалт зохион байгуулах. | Улсын төсөв, төсөл хөтөлбөр | Сургалт нөлөөллийн ажиллагаа зохион байгуулсан ажлын гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 1. 2023 онд батлагдсан сургалтын үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөний дагуу тайлант хугацаанд нийт 309 удаагийн 472 цагийн сургалтыг зохион байгуулж 17107 хүнийг хамруулсан. Нийслэлийн хэмжээнд 54 удаагийн сургалт 4143 оролцогч, орон нутагт 255 удаагийн сургалт 12,964 оролцогчтой сургалтуудыг амжилттай зохион байгуулж ажилласан байна. Үүнээс онцлох сургалтыг дурдвал:<br>- УИХ-ын гишүүдийн ажлын алба, УИХ дахь намын бүлгүүд, УИХТГ-ын 90 гаруй алба хаагчдад “Хүний эрхэд суурилсан бодлого, төлөвлөлт”, “Технологи, Хүний хувийн мэдээлэл, хүний эрхийн эрсдэл” сэдэвт сургалтыг зохион байгуулсан,<br>- “Ажлын байрны дарамт хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь сэдэв”-т 7 удаагийн 13 цагийн сургалтад 258 оролцогчийг хамруулсан.<br>- “Хүний эрх хамгаалагч гэж хэн бэ?”, “Хүний эрх хамгаалагчийн эрх, хамгаалалт”, “Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилт”, “Хүний эрх хамгаалагчийг хамгаалах тогтолцоо”, “Аюулын зэрэг тогтоох, эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал”, "Хүний эрх хамгаалагчдад тулгамдаж буй асуудал, хүндрэл бэрхшээл, хориглох заалт" зэрэг сэдвээр нийт 19 удаагийн сургалт зохион байгуулснаас 17 удаагийн танхимын, 2 удаагийн цахим сургалтад өмгөөлөгчид, сэтгүүлчид, үйлдвэрчний эвлэлийн сонгуульт ажилтнууд, ХЭХХ-ны гишүүд, хэлтсийн ажилтнууд, Комиссын орон нутгийн ажилтнууд, иргэд, малчид зэрэг нийт 772 оролцогчийг хамруулсан.<br>- Цагдаагийн байгууллагын алба хаагчдад зориулан "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээллийг иргэд олон нийтэд хүргэхэд хүний эрхийг хангах" сэдвээр видео хичээл бэлтгэн ЦЕГ-ын цахим сургалтын талбарт байршуулсан.<br>2. Зорилтод бүлэгт чиглэсэн хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагаа, тэдний мэдлэг хандлагыг дээшлүүлэх, чадавхжуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор тайлант хугацаанд 29 удаагийн 66 цагийн хүний эрхийн сургалтад 1506 оролцогчийг хамруулсан. | 90 |
| 4.1.2 | Арга хэмжээ 4.1.2: Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй гэсэн зохицуулалтын агуулга, мөн чанарыг ойлгуулахад чиглэсэн | Улсын төсөв, төсөл хөтөлбөр | Боловсруулсан сургалтын модулийн тоо | 0 | 5 | 1. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн хялбаршуулсан брошюрыг бэлтгэж 2000 хувь хэвлүүлж олон нийтэд тараан сурталчилж байна.<br>2. “Урбан Иргэдийн Форум Холбоо” НҮТББ-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж “Тайван хуран чуулах эрх чөлөөний зарчим”-уудаар 17 постер хүлээж авсан. Комиссын цахим хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд хүргэхэд бэлэн болсон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нөлөөллийн үйл ажиллагаа явуулах.<br>- Жагсаал, цуглааны үеэр хүний эрхийг сахин биелүүлэхэд нөлөөлөх сурталчилгааны багц материалыг бэлтгэх. | | | | | | |
| 4.1.3 | Арга хэмжээ 4.1.3: Монголын Хуульчдын холбоогоор дараах хичээлүүдийн хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх.<br>- “Хүний эрхийн олон улсын гэрээ”;<br>- “Хүний халдашгүй чөлөөтэй байх эрх”;<br>- “Шударга шүүхээр шүүлгэх эрх”;<br>- “Нийтийн ашиг сонирхлыг шүүхээр хамгаалах нь”. | Улсын төсөв, төсөл хөтөлбөр | Магадлан итгэмжлүүлэхээр хүргүүлсэн хөтөлбөрийн тоо | 0 | 4 | Монголын хуульчдын холбоогоор магадлан итгэмжлүүлэх "Хүний халдашгүй чөлөөтэй байх эрх", “Шударга шүүхээр шүүлгэх эрх”, “Нийтийн ашиг сонирхлыг шүүхээр хамгаалах нь”, “Хүний эрхийн олон улсын гэрээ” хичээлийн хөтөлбөр бэлэн болсон. | 100 |
| 4.1.4. | Арга хэмжээ 4.1.4: Хүний эрх хамгаалагчийн талаар гарын авлага, модуль боловсруулан гаргах. | Улсын төсөв, төсөл хөтөлбөр | Гарын авлага, модуль боловсруулсан байна. | 0 | 1 | “Монголын сэтгэл судлалын мэргэшсэн мэргэжлийн төв” болон Монголын эмнести интернэшнлийн сургагч багш нараар гэрээлэн гүйцэтгүүлсэн Хүний эрх хамгаалагч сургалтын модулийг 2023.10.30-ны өдөр хүлээн авч, Хүний эрх хамгаалагчийн хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтад ашигласан. | 100 |
| 4.1.5 | Арга хэмжээ 4.1.5: “Эрх зүйн хөтөч" бэлтгэх сургалтын хөтөлбөрт “Хүний эрхэд суурилсан хандлага”, “Хүний эрхийн зөрчлийг бусад эрх зүйн зөрчлөөс ялгаж таних нь”, “Жендэр ба хүний эрх" зэрэг сэдвийг тусгах. | Улсын төсөв | Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хариуцах заалтын хэрэгжилтийн хувь | 0 | 100% | Эрх зүйн хөтөч бэлтгэх сургалтын хөтөлбөрт төлөвлөгөөний дагуу "Хүний эрхэд суурилсан хандлага", "Жендэр ба хүний эрх сэдэв"-ийг тусгаж бичлэгт орсон. Мөн "Хүний эрхийн олон улсын гэрээ", "Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенц"-ын агуулгаар хичээл бэлтгэж улсын өмгөөлөгч, хуульчдад сургалт зохион байгуулж Эрх зүйн хөтөч бэлтгэх сургалтын хөтөлбөрт нэмэлтээр тусгуулсан бөгөөд хичээлийн видео бичлэг хийлгэсэн. | 100 |
| 4.1.6 | Арга хэмжээ 4.1.6: МҮОНРТ-тэй хамтран нэвтрүүлэг хийх.<br>- Сэтгэцийн эрүүл мэнд хүний эрх;<br>- Хүний эрх ба цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ;<br>- ЕБС-ийн дотуур байр ба хүүхдийн эрх; | Улсын төсөв | Олон нийтийн хүргэсэн нэвтрүүлгийн тоо | 0 | 5 | 1. МҮОНРТ-тэй хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд 5 нэвтрүүлэг хийхээр төлөвлөсөн ба “Цахим орчинд хүүхэд хамгаалал”, “ЕБС-ийн дотуур байр ба хүүхдийн эрх” сэдвээр 2 нэвтрүүлэг бэлтгэж МҮОНРТ-ийн эфирээр тус бүр 2 удаа цацагдаж “Mongolian Broadcasting Television” пэйж хуудаснаас нийт 45 мянган хүн үзсэн.<br>2. МҮОНРТ-ийн холбогдох албан тушаалтантай 2023.09.11-ний | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | - Цахим орчин дахь хүүхэд хамгаалал;<br>- Технологи ба хүний эрх. | | | | | өдөр уулзалт зохион байгуулж, Сэтгэцийн эрүүл мэнд хүний эрх, Хүний эрх ба цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ , Технологи ба хүний эрх нэвтрүүлгийн ажлыг дуусгах асуудлаар харилцан тохиролцсон боловч МҮОНРТ-ийн зүгээс 10 дугаар сард Комисстой хамтран ажиллах боломжгүй гэж мэдэгдсэн. | |
| 4.1.7 | Арга хэмжээ 4.1.7: Хүний эрх хамгаалагчийн талаар баримтат нэвтрүүлэг хийх. | Төсөл хөтөлбөр | Олон нийтэд хүргэсэн нэвтрүүлгийн тоо | 0 | 1 | Хүний эрх хамгаалагчийн талаар хийх баримтад нэвтрүүлгийн зохиол, агуулгыг тодорхойлж, шаардлагатай төсвийн тооцоог гаргасан боловч шаардагдах төсөв 2023 онд батлагдаагүй тул хэрэгжүүлэх боломжгүй болсон. | - |
| 4.1.8 | Арга хэмжээ 4.1.8: Хүний эрх хамгаалагчийн талаар видео контент бэлтгэх, цахим постер хийх. | Төсөл хөтөлбөр | Нөлөөллийн Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | Хүний эрх хамгаалагчийн талаар хийсэн 6 удаагийн подкастад ашиглагдсан 17 постер, "Хүний эрх хамгаалагчийн эрх, хамгаалалт" хэлэлцүүлгийн цахим баннер 2, Хүний эрх хамгаалагчийн хорооны гишүүнд нэр дэвшигчдийн талаарх танилцуулга постер 5, Нээлттэй сонсгол зохион байгуулах тухай зар 2, Хүний эрхийг хамгаалагчийн тухай Тунхаглал 9, Хүний эрх хамгаалагч-Зоригтон арга хэмжээнд 15 цахим постер, 2 видео шторк бэлтгэж олон нийтэд түгээсэн. | 100 |
| 4.1.9 | Арга хэмжээ 4.1.9: Ховд, Увс, Баян-Өлгий, Дундговь, Дорноговь, Дорнод Баянхонгор, Өвөрхангай, аймгуудад хүний эрх хамгаалагчийн эрхийн талаар сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх. | Улсын төсөв | Нөлөөллийн Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 2. Хүний эрх хамгаалагчийг хамгаалах механизмыг сурталчлах үйл ажиллагааны хүрээнд 2023.04.10-19-ний өдрүүдэд Дорнод, Дорноговь, Дундговь аймагт томилолтоор ажиллаж 28 удаагийн уулзалтаар 279, 2023.06.05-19-ний өдрүүдэд Увс, Баян-Өлгий, Ховд аймгуудад 16 удаагийн уулзалтаар 233 төрийн алба хаагчид, иргэд, малчидтай уулзаж, тэдэнтэй хүний эрх хамгаалагчийг хамгаалах шинэ механизмыг сурталчлан таниулж, санал солилцов. | 100 |
| 4.2 | Зорилт 4.2. Албан болон албан бус боловсролын тогтолцоонд хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг дэмжих. | | | | | | |
| 4.2.1 | Арга хэмжээ 4.2.1: Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад хүний эрхийн ойлголт өгөх сургалтыг сайн дурын бүлгүүдтэй хамтран үе шаттай зохион байгуулах. | Улсын төсөв | Зохион байгуулсан сургалтын тоо | 0 | 20 | 1. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын хүний эрхийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2023.05.19-ний өдөр "Үндсэн хууль манай сургуульд" сэдэвт сургагч багшийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагын гишүүд, Комиссын дэргэдэх Иргэний нийгмийн зөвлөлийн гишүүд, хуульч, өмгөөлөгчид нийт 40 хүн хамрагдсан. Бэлтгэдсэн сургагч багш нартай хамтран "Цахим орчин дахь хүүхдийн эрх", "Хууль дээдлэх ёс", "Шударгаар шүүлгэх эрх", "Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх", "Тэгш эрхийн зарчим, ялгаварлан гадуурхалтыг хориглох нь" сэдвээр Архангай аймгийн Лаборатори 1 дүгээр сургууль, Нийслэлийн ерөнхий боловсролын 93, 33, 14 дүгээр | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургуулийн сурагчид, Бодлогод залуусын хяналт ТББ-ын дэргэдэх Залуучуудын клубын гишүүд, Кристина Ноблийн Хүүхдийн Сан, Хүүхэд Ивээн Тэтгэх Хөтөлбөрийн хүүхдүүд нийт 188 сургагчдад хүний эрхийн сургалт зохион байгуулсан. 2023.06.09-ний өдөр сургагч багш нарыг “Насанд хүрээгүй хүнд сургалт орох арга зүй” сэдэвт сургалтад хамруулж, сургагч багшийн гэрчилгээ гардуулсан. Сургагч багш нар 2023 оны 06-12 дугаар сард Нийслэл, 21 аймагт 51 удаагийн сургалт зохион байгуулж ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 7583 сурагчийг хамруулсан. Орон нутаг дахь албан хаагчид ерөнхий боловсролын сургуулийн 1215 ахлах ангийн сурагчдад “Нууцтай байх эрх”, “Хүүхдийн эрх, хамгаалал” сэдэвт сургалт орсон.<br>2. Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал батлагдсаны 75 жилийн ойг тохиолдуулан “Манай ангид-Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал” аяныг зохион байгуулж үндэсний хэмжээнд 247 ерөнхий боловсролын сургууль, 19 их, дээд сургууль, политехникийн коллеж нэгдэж хичээлийн шинэ жилийн эхний өдөр Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын агуулгыг зааж, бага насны хүүхэд, сурагчид, оюутан залуусын хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлсэн.<br>3. Ерөнхий боловсролын 3 дугаар дунд сургуулийн ахлах ангийн 35 сурагч, МУБИС-ийн нийгмийн ухааны 46 оюутанд “Хүний эрх хамгаалагч” кино хэлэлцүүлэг хийсэн. | |
| 4.2.2 | Арга хэмжээ 4.2.2: Албан боловсролын бүх шатны сургалтын хөтөлбөрт хүний эрхийн мэдлэг олгох агуулгыг зарим хичээлийн онцлогтой уялдуулан өргөжүүлэх.<br>- Их дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, агуулгад хүний эрхийн хичээлийн хөтөлбөр, агуулга байгаа эсэхтэй танилцах, санал өгөх, хүний эрхийн арга зүйн зөвлөгөө өгөх. /ДХИС, СУИС/. | Улсын төсөв | Сургалтын хөтөлбөрт шинээр тусгуулахаар хүргүүлсэн саналын тоо | 2 | 4 | 2022 онд ДХИС, СУИС-ийн сургалтын хөтөлбөр, агуулгад хүний эрхийн хичээлийн хөтөлбөр, агуулга байгаа эсэхтэй танилцаж, сургалтын хөтөлбөрт сэдэв тусгах талаар арга зүйн зөвлөгөө өгсөн. | 100 |
| 4.2.3 | Арга хэмжээ 4.2.3: Комиссын бүрэн эрх, мандатын хүрээг тайлбарласан цуврал видео контентыг бэлтгэж, олон нийтэд түгээх. | Улсын төсөв | Бэлтгэсэн контентын тоо | 0 | 1 | Комиссын бүрэн эрх, мандатын хүрээг тайлбарласан видео контентыг бэлтгэж, олон нийтэд түгээхээр бэлтгэж байна. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.4 | Арга хэмжээ 4.2.4: Зорилтод бүлэгт чиглэсэн хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагаа, тэдний мэдлэг хандлагыг дээшлүүлэх, чадавхжуулахад дэмжлэг үзүүлэх.<br>- Иргэний нийгмийн зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах, хүний эрхийн сургагч багшийн сургалтад хамруулах;<br>- Хүний эрх хамгаалагчийн хорооны гишүүд, Хүний эрх хамгаалагчийн хэлтсийн ажилтнуудыг чадавхжуулах, хүний эрхийн сургагч багшийн сургалтад хамруулах;<br>- Архангай аймаг дахь "Тэгш тусгал" ТББ-ын орон нутгийн гишүүдэд зориулсан хүний эрхийн сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулах;<br>- Цагдаагийн байгууллагын албан хаагчдад зориулсан “Хүний эрхийн сургагч багш” бэлтгэх, "Хөгжлийн бэрхшээлтэй хохирогчийн онцлогт тохирсон харилцах арга зүй" сургалт зохион байгуулах;<br>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдад зориулсан “Хүний эрхийн сургагч багш” бэлтгэх, "Хөгжлийн бэрхшээлтэй хохирогчийн онцлогт тохирсон харилцах арга зүй" сургалт зохион байгуулах;<br>- Зэвсэгт хүчний жанжин штабын албан хаагчдад зориулсан “Хүний эрхийн сургагч багш” бэлтгэх, "Хөгжлийн бэрхшээлтэй хохирогчийн онцлогт тохирсон харилцах арга зүй" сургалт | Улсын төсөв, төсөл хөтөлбөр | Сургалт нөлөөллийн ажиллагаа зохион байгуулсан ажлын гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | - Комиссын дэргэдэх Иргэний нийгмийн зөвлөлийн гишүүн М.Энхбадрал, Б.Ардак, Б.Цэцэгсүрэн, Б.Өлзийсайхан нарыг 2023.05.19-ний өдөр ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад хүний эрхийн хичээл заах хүний эрхийн сургагч багшаар бэлтгэж, сертификат олгосон. Комиссын дэргэдэх Иргэний нийгмийн зөвлөл, Хүний эрх хамгаалагчийн хорооны 18 гишүүний хүний эрхийн мэдлэг ойлголтыг бэхжүүлж, чадавхжуулах зорилгоор хүний эрхийн сургагч багш бэлтгэх сургалтад 2023.11.18, 19-ний өдрүүдэд хамруулж, гэрчилгээ олгов.<br>- Цагдаагийн ерөнхий газрын харьяа алба, газар, нэгжийн хүний эрхийн сургагч багшаар бэлтгэгдсэн 30 алба хаагчийн хүний эрхийн мэдлэг, ойлголтыг бататгаж, “Хохирогч төвтэй мөрдөн шалгах ажиллагаа” сэдвийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хохирогчтой харилцах арга зүй олгох сургалтыг 2023.05.08, 09-ний өдөр ЦЕГ-тай хамтран зохион байгуулсан. Тус сургагч багш нарын хичээл заажбуй байдалд хяналт тавих үүднээс 2023.06.08-ны өдөр зохион байгуулсан ЦЕГ-ын Гэрч хохирогчийг хамгаалах хэлтэс, Тусгай ажиллагааны газрын 58 алба хаагчдад зориулсан сургалтад Комиссын төлөөлөл ажиглагчаар оролцсон.<br>- “Тэгш тусгал” ТББ-ын орон нутгийн гишүүдийн хүний эрхийн мэдлэг, ойлголтыг бэхжүүлэх, үйл ажиллагаандаа хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйг төлөвшүүлэн хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмэгтэйчүүдийн хүний эрхийн боловсролыг нэмэгдүүлэх, түгээх зорилгоор хүний эрхийн сургагч багш бэлтгэх сургалтыг 2023.06.06-09-ний хооронд Архангай аймагт зохион байгуулсан.<br>- 2023.10.25, 26-ны өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын алба, газар, хэлтэс, хорих анги, аймаг, нийслэл дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 50 алба хаагчдыг хүний эрхийн сургагч багшаар бэлтгэж, гэрчилгээ олгохын зэрэгцээ “Хөгжлийн бэрхшээлтэй хоригдолтой ажиллах арга зүй” сэдвээр багийн ажил хийлгэж, чиглэл, мэдээлэл өгсөн. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулах;<br>- Хил хамгаалах байгууллагын албан хаагчдад “Хүний эрхийн сургагч багш” бэлтгэх, "Хөгжлийн бэрхшээлтэй хохирогчийн онцлогт тохирсон харилцах арга зүй" сургалт зохион байгуулах. | | | | | | |
| 4.2.5 | Арга хэмжээ 4.2.5: Хүний эрхийн талаарх бүх нийтийн боловсрол олгох албан бус үйл ажиллагааг дэмжих, хамтран ажиллах.<br>- Зорилтот бүлэгт чиглэсэн “Хүний эрхийг хангах 10 алхам” брошур бэлтгэх;<br>- "Хүний эрхийн тухай ярилцъя" уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах;<br>- Хүний эрхийн хүндэтгэлийн лекц зохион байгуулах;<br>- Хүний эрхийн боловсрол олгох контентыг, төлөвлөгөөний дагуу бэлтгэж, нийгмийн сүлжээгээр түгээх;<br>- Холбогдох хэлтсээс бэлтгэсэн агуулгын хүрээнд судалгаа, дүн шинжилгээний үр дүнг олон нийтэд сурталчлах;<br>- Мэдээлэл авах эрх, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг сурталчлах цахим постер, видео шторк, бэлтгэж, сурталчлах; | Улсын төсөв, төсөл хөтөлбөр | Хамтран ажилласан ажлын гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 1. Хүний эрхийн талаарх бүх нийтийн боловсрол олгох албан бус үйл ажиллагааг дэмжих Хуульчдын Про боно өдөрлөг, Үндэсний номын баярын өдрөөр иргэдэд хууль, эрх зүйн зөвлөгөө өгч, ном гарын авлага тараах ажилд оролцож, зохион байгуулсан. Хүний эрх сэтгүүл, Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо судалгааны тайлан, Улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдал, Хүүхдийн хөдөлмөрийн чанарын судалгаа зэрэг судалгааг Комиссын мэдээллийн самбар, цахим хуудас, олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж ажилласан.<br>2. Зорилтот бүлэгт чиглэсэн “Хүний эрхийг хангах 10 алхам” брошурыг Монголын Хуульчдын холбоотой хамтран гаргахаар тохиролцож хүний эрхийн брошурын агуулга гаргуулахаар болсон бөгөөд эмч, цагдаагийн албан хаагчдад зориулсан брошурын гарын авлага ирснийг хянаж байна.<br>3. "Хүний эрхийн тухай ярилцъя" уулзалт, хэлэлцүүлгийн санхүүжилт шийдвэрлэгдээгүй тул зогссон.<br>4. “Хүний эрхийн тухай ярилцъя” хүндэтгэлийн лекцийг 2023.12.20-ны өдөр зохион байгуулсан. “Монгол Улс дахь Хүний эрх-Эдийн засаг, нийгэм, соёлын эрхэд анхаарал хандуулах нь” сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан хүндэтгэлийн лекцэнд Монгол Улс дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Суурин зохицуулагч Тапан Мишра урилгаар оролцож, “Тогтвортой хөгжлийн зорилгуудын хэрэгжилтэд хүний эрхийн шалгуурыг хангах нь” сэдвээр илтгэл тавьж, хэлэлцүүлэг өрнүүлсэн.<br>4. Хүний эрхийн боловсрол олгох контентын хүрээнд тэмдэглэлт өдрийн 298 постер, мэндчилгээний 44 постер, хүний эрхийн сурталчилгааны 69 постер, 30 цахим урилга, 1 шторк, уулзалт, хэлэлцүүлэг, сургалтын 20 баннер хийн олон нийтийн сүлжээгээр түгээсэн.<br>Хүний эрх сэтгүүл, Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо судалгааны тайлан, Улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдал, Хүүхдийн хөдөлмөрийн чанарын судалгаа | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зэрэг судалгааг олон нийтэд сурталчилж цахим хуудсанд байршуулсан. | |
| 4.2.6 | Арга хэмжээ 4.2.6: Хүний эрхийн ном, товхимол орчуулах, боловсруулах, хэвлүүлэх.<br>- Комиссын гишүүдийн шаардлага, зөвлөмжийн эмхэтгэл хэвлэн гаргах, цахим хуудаст байршуулах;<br>- Хүний эрхийн тайлбар толь боловсруулах;<br>- Хууль, хяналтын байгууллагын албан хаагчдад зориулсан хүүхэдтэй ажиллах заавар боловсруулж хэвлэх;<br>- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургагч багшийн гарын авлага хэвлүүлэх;<br>- Байгаль орчны чиглэлээр ажилладаг хүний эрх хамгаалагчийн гарын авлага орчуулж, хэвлүүлэх;<br>- Хүний эрх хамгаалагчийн цахим орчинд аюулгүй байдлаа хангах практик зааварчилгааг хэвлүүлэх;<br>- Хүний эрх хамгаалагчийн эрхийн хэрэгжилт судалгааны тайланг хэвлүүлэх. | Улсын төсөв, төсөл хөтөлбөр | Зохион байгуулсан арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 1. Комиссын гишүүдийн шаардлага, зөвлөмжийг цахим хуудаст байршуулж байна.<br>2. “Байгаль орчны салбарын хүний эрх хамгаалагчдын Ази, Номхон далайн сүлжээ” байгууллагаас эрхлэн гаргасан “Байгаль орчны салбар дахь хүний эрх хамгаалагчдад зориулсан гарын авлага”-ыг тус байгууллагын зөвшөөрлөөр орчуулан хянаж, 500 хувийг хэвлүүлж, орон нутагт томилолтоор ажиллахдаа байгаль орчны хүний эрхийн асуудлаар ажилладаг иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүд, иргэд, малчдад түгээж байна.<br>- Хүүхдийн хөдөлмөрийн чанарын судалгаа, Цэргийн алба хаагчдын дүрмийн бус харьцааны нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээг хэвлэлтээс хүлээн авч холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.<br>- “Байгаль орчны салбарын хүний эрх хамгаалагчдын Ази, Номхон далайн сүлжээ” байгууллагаас эрхлэн гаргасан “Байгаль орчны салбар дахь хүний эрх хамгаалагчдад зориулсан гарын авлага”-ыг тус байгууллагын зөвшөөрлөөр орчуулан хянаж, 500 хувийг хэвлүүлж, орон нутагт томилолтоор ажиллахдаа байгаль орчны хүний эрхийн асуудлаар ажилладаг иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүд, иргэд, малчдад түгээж байна.<br>- Хүний эрх хамгаалагчийн эрхийн хэрэгжилт судалгааны тайланг цахим хэлбэрээр Комиссын номын санд байршуулсан.<br>- Хүний эрхийн Үндэсний Комиссын танилцуулгын эхийг монгол, англиар бэлтгэн хэвлэлтэд бэлэн болгон англи хувилбарыг 30 хувь хэвлүүлсэн.<br>- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургагч багшийн гарын авлага хэвлүүлэх төсөв, санхүүжилт байхгүйгээс цахим хувийг Комиссын цахим номын санд байршуулж олон нийтэд хүргэсэн. - Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 75 жилийн ойг тохиолдуулан ХЭХХ-ээс санаачлан “Хүний эрх хамгаалагчдад зориулсан хууль тогтоомжийн эмхэтгэл” өврийн номыг 2000 хувь хэвлүүлж, олон нийтэд түгээж байна. | 100 |
| 4.2.7 | Арга хэмжээ 4.2.7: Урлагаар дамжуулж хүнлэг соёлыг түгээн дэлгэрүүлэх хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх.<br>- Залуу уран бүтээлч, контент | Улсын төсөв | Зохион байгуулсан арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | Урлагаар дамжуулж хүнлэг соёлыг түгээн дэлгэрүүлэх ажлын үзэл баримтлал хийгдэх ажлын ерөнхий төлөвлөгөө, төсвийг гаргасан ба санхүүжилтгүйн улмаас хойшилсон. Санхүүжилт шийдвэрлэх талаар тодорхой ажлууд үргэлжилж байна. | 10 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бэлтгэгч нартай уулзалт зохион байгуулж хамтран ажиллах. | | | | | | |
| 4.2.8 | Арга хэмжээ 4.2.8: “Хөгжлийн бэрхшээлтэй Монгол хүн” нөлөөллийн кампанит ажлыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай уялдуулж явуулах. | Улсын төсөв | Зохион байгуулсан арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 1. “Хүнлэг Монгол” нөлөөллийн кампанит ажлыг зохион байгуулах, санхүүжилт олох төсөл боловсруулж ОУ-ын байгууллагууд руу илгээсэн.<br>2. UNESCO- ийн Бээжин хот дахь Салбарын захирал Shahbaz Khan-тай Залуу судлаачдыг дэмжих сангийн судлаачдын төлөөллийн оролцуулан уулзалт хийж Хүнлэг Монгол хүн нөлөөллийн кампанит ажлын талаар болон Хүний эрхийн тайлбар толь гаргах асуудлаар танилцуулга хийсэн боловч 2023 онд санхүүжилт шийдвэрлэгдээгүй тул уг арга хэмжээ хэрэгжээгүй. | - |
| 4.2.9 | Арга хэмжээ 4.2.9: Ажлын байрны дарамт, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтыг бууруулах, урьдчилсан сэргийлэхэд чиглэсэн нэг сарын аяныг зохион байгуулах. | Улсын төсөв | Зохион байгуулсан арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 1. Ажлын байрны дарамт, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтыг бууруулах, урьдчилсан сэргийлэхэд чиглэсэн нэг сарын аяныг 2023.10.01-нээс 31-ний өдрийн хооронд өрнүүлсэн. Аяны хүрээнд сургалтын гарын авлага ппт, сурталчилгаа, нөлөөллийн хүрээнд 12 постер, 4 шторк бэлтгэн Комиссын цахим хуудас, фейсбүүк хуудсаар түгээж ажилласан. Комиссын Фейсбүүк хуудсаар дамжуулсан аяны сурталчилгаа 120,000 хүнд хүрсэн бөгөөд аяны хүрээнд Комиссын гишүүн алба хаагчид 4 телевиз, 6 сайт, 2 сайтад ярилцлага, тодруулга яриа өгчээ.<br>Тус аянд Эрүүл мэндийн яам нэгдэж харьяа бүх эмнэлгийн байгууллагадаа “Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх” сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. Аяны хүрээнд 21 аймаг, Нийслэлийн хэмжээнд “Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх нь” сэдвээр 45 удаагийн 54.5 цагийн сургалтад 1952 оролцогчтой сургалтыг зохион байгуулсан байна. | 100 |
| 4.2.10 | Арга хэмжээ 4.2.10: Хүний эрх хамгаалагчийн олон улсын тэмдэглэлт өдрийг угтан (2023.11.29, 2023.12.09) хүний эрх хамгаалагчдын үйл ажиллагааг сурталчлах аяныг зохион байгуулах. | Улсын төсөв, Төсөл хөтөлбөр | Зохион байгуулсан компанит ажлын тоо | 0 | 1 | Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал батлагдсаны 75 жил, Хүний эрх хамгаалагчийн тухай тунхаглал батлагдсаны 25 жилийн ойг тохиолдуулж Монголын Эмнести Интернэшнл, “Оюу Толгойн хяналт” ТББ, “Монголын Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв”, Монголын эмэгтэйчүүдийн сангаас хамтран 2023.11.29-ны өдөр ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧ ЗОРИГТОН-2023” хөрөг найрууллын уралдааныг зохион байгуулсан. “Хүний эрх хамгаалагч зоригтон-2023” хөрөг найрууллын уралдааны хүрээнд мэдэх эрх, сонгох эрх, цэвэр усаар хангагдах эрх, эмэгтэйчүүдийн эрх болон эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамгаалагчдын талаарх сэтгүүл зүйн МОЖО төрлийн 11 бүтээл хүлээн авч, 5 бүтээл шалгарсан. | |
| 4.2.11 | Арга хэмжээ 4.2.11: “Хүний эрх” эрдэм шинжилгээний сэтгүүлийг эрхлэн гаргаж, олон нийтэд хүргэх.<br>- “Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо, зөрчигдсөн эрхийг сэргээх механизмийг боловсронгуй болгох нь”. | Улсын төсөв | Шинээр гаргасан сэтгүүлийн тоо | 0 | 2 | “Хүний эрх” эрдэм шинжилгээний сэтгүүлийн эхний дугаарт нийт 9 нийтлэл ирүүлснийг редакцын зөвлөл хянаж, ХЭССХ эмхэтгэн 6 нийтлэл, 1 орчуулгын нийтлэл, 1 ярилцлагатайгаар 500 хувь хэвлүүлэн олон нийтэд түгээсэн. Сэтгүүлийн 2 дахь дугаарыг тайлант хугацаанд 3 нийтлэл ирсэн байгааг хянаж редакцийн зөвлөлд шилжүүлээд байна. | 90 |
| Стратегийн зорилго тав. Хүний эрхийн салбарт олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх | | | | | | | |
| Алсын хараа 2050: 5.5.5.Хүний эрхийг хангахад төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжиж хамтран ажиллана. | | | | | | | |
| МУХЭҮКТХ: 7.1.3.хүний эрхийн талаарх олон улсын гэрээнд нэгдэн орох, соёрхон батлах эсэх талаар санал хүргүүлэх, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөл болон гэрээний хороодод мэдээлэл хүргүүлэх; | | | | | | | |
| 5.1 | Зорилт 5.1: Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн механизмтай ажиллах үндэсний чадавхыг бэхжүүлэх. | | | | | | |
| 5.1.1 | Арга хэмжээ 5.1.1: Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээний хороод болон хүний эрхийн төлөв байдлын ээлжит хэлэлцүүлгийн хүрээнд Нэгдсэн Үндэстний байгууллагын гишүүн улсуудаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх, дундын тайлагнах механизмыг тогтвортой ажиллуулахад чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа явуулах. | Улсын төсөв | Нөлөөллийн үйл ажиллагаа явуулсан ажлын гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооны “Монгол Улсын олон талт гэрээний хэрэгжилтийг судлах” үүрэг бүхий Ажлын хэсгээс 2023.06.14, 20-ны өдрүүдэд зохион байгуулсан НББХ, БОХХААБХ-ны хуралдаанд Комиссын төлөөлөл оролцсон. Комиссын дарга Ж.Хунан 2023.10.19-нд ГХЯ-ны н.Золбоотой уулзаж уг асуудлаар санал солилцсон. | 100 |
| 5.1.2 | Арга хэмжээ 5.1.2: Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн механизмаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих, Засгийн газрын бүтцийн үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллах. | Улсын төсөв | Нөлөөллийн үйл ажиллагаа явуулсан ажлын гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл, гэрээний хороодоос өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг тайлагнах салбар дундын механизмыг бий болгох чиглэлээр хамтран ажиллах асуудлаар Хүний эрхийн Үндэсний Хорооны Ажлын албатай уулзалт хийсэн. | - |
| 5.1.3 | Арга хэмжээ 5.1.3: Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийг хамгаалах тогтолцооны | Улсын төсөв, ОУБ-ын санхүүжилтээр | Хамтарч ажилласан ажлын | 0 | 100 | 1. 2023.02.07-ноос 12-ны хооронд Швейцарийн Холбооны Улсын Женев хотноо зохион байгуулагдсан "Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт протокол батлагдсаны 20 жилийн ой", "Эрүү | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагуудтай хамтран ажиллах. | | гүйцэтгэлийн хувь | | | шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны 15 жилийн ой"-д зориулсан хурал, арга хэмжээнд Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх асуудалд эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн гишүүн оролцож Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны дарга, гишүүдтэй уулзаж цаашдын хамтын ажиллагааны талаар ярилцсан.<br>2. Комиссын дарга 2023.03.13-наас 17-ны өдрүүдэд Швейцарийн Холбооны Улсын Женев хотноо хийсэн айлчлалын хүрээнд Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн тусгай илтгэгч Мэри Лавлор, шүүгч, хуульчдын хараат бус байдлын асуудал хариуцсан тусгай илтгэгчийн туслах, хүний эрхийн ажилтан Мэлани Сантизо, Дур зоргоор албадан саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн гишүүн Прия Гопалан болон хүний эрхийн ажилтан Маргарита Нечаева, Хүн худалдаалах (хүүхэд, эмэгтэйчүүд) асуудал хариуцсан тусгай илтгэгч Сиобхан Муллали, НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын албаны Ази-Номхон далайн бүсийн дарга Рори Мүнговен, Монгол Улсыг хариуцсан ажилтан Себастьен Гиёо, Хөгжих эрхийн хэлтсийн дарга А.Бат-Эрдэнэ нартай уулзалт хийсэн.<br>3. НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооны Ажлын албанаас ирүүлсэн захидлын дагуу Швейцарын Холбооны Улсын Женев хотноо 2023.08.13-16-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын 2, 3 дахь тайлан хэлэлцэх 29-р чуулганы” хуралдаанд Комиссын гишүүн Г.Нарантуяаг оролцсон.<br>4. Комиссын гишүүн Б.Энхболд 2023.09.18-ны өдөр НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн 54 дүгээр чуулганы хуралдаанаар Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн дүгнэлтийг танилцуулахтай холбогдуулж видео мэдээлэл хийсэн. | |
| 5.2 | Зорилт 5.2: Олон улсын хүний эрхийн эрх зүйг хэрэглэх үндэсний чадавхыг бэхжүүлэх. | | | | | | |
| 5.2.1 | Арга хэмжээ 5.2.1: Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн механизмаас Монгол Улсад өгсөн зөвлөмжүүдийг Засгийн газрын байгууллагуудаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээний хороодоос гаргасан ерөнхий зөвлөмжийг орчуулах, | Улсын төсөв | Дэмжлэг үзүүлсэн үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 1. НҮБ-ын гэрээний хороодоос гаргасан ерөнхий тайлбар зөвлөмжүүдийн монгол хэлээр орчуулагдаагүй хэсгийн жагсаалтыг гаргаж НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны Хүүхдийн эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалахад хараат бус ХЭҮБ-ын гүйцэтгэх үүрэг сэдэвт 2 дугаар Ерөнхий зөвлөмжийг орчуулж “Үндсэн хууль манай сургуульд” гарын авлагад тусгасан.<br>2. Комиссын гишүүн Б.Энхболд Шүүхийн сургалтын төвд “Халдашгүй чөлөөтэй байх эрх”-ийн талаарх ИБУТЭТОУП-ын 9 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | практик хэрэглээнд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх. | | | | | дүгээр зүйлийн талаарх 35 дугаар ерөнхий зөвлөмжийн талаар сургалтын контентод орох хичээлийн бичлэг хийлгэсэн. | |
| 5.2.2 | Арга хэмжээ 5.2.2: Хүний зөрчигдсөн эрхийг сэргээхэд олон улсын хүний эрхийн механизмыг ашиглах, туршлагыг практикт нэвтрүүлэх.<br>- Иргэний гомдлын асуудлаар олон улсын хүний эрхийн механизмд хандахад дэмжлэг үзүүлэх. | Улсын төсөв | Холбогдох байгууллагууда д уламжилсан зөвлөмжийн тоо | 0 | 1 | 1. НҮБ-ын хүний эрхийн механизмд хувь хүн хэрхэн гомдол гаргах талаар иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгч улмаар Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид 2016 оны Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг тайлбарлах замаар ижил төстэй эрх зүйн байдалд буй иргэдийн эрх зүйн байдлыг дээрдүүлэхэд хамтран ажиллах хүсэлт гаргасан.<br>2. Иргэн Ц.Чулуунтогтоход НҮБ-ын хүний эрхийн механизмд хувь хүн хэрхэн гомдол гаргах талаар зөвлөгөө, мэдээлэл өгсөн. Улмаар уг иргэн үндэсний эрх зүйн орчинд эрх зүйн байдлаа сайжруулах арга хэмжээ авахаар болсон. | 100 |
| 5.2.3 | Арга хэмжээ 5.2.3: Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, хүний эрхийн олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх үндэсний чадавхыг бэхжүүлэхэд Европын Хүний эрхийн Шүүх, Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээний хороодын туршлагыг судалж, Монгол Улсын онцлогт нийцүүлсэн хэрэглээг төлөвшүүлэх.<br>- Европын хүний эрхийн шүүхийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах хөтөлбөр боловсруулах, холбогдох байгууллагуудад санал гаргах. | Улсын төсөв | Нөлөөллийн үйл ажиллагааны гүйцэтгэлтийн хувь | 0 | 100 | Европын холбооны TAIEX төсөлд хамрагдахаар санал Европын хүний эрхийн шүүх, ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхийн туршлагаас судлах саналаа Европын холбооны Монгол Улс дахь төлөөлөгчийн газарт хүргүүлсэн. | 100 |
| 5.2.4 | Арга хэмжээ 5.2.4: Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах асуудлаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн механизмтай хамтран ажиллах. | Улсын төсөв | Хамтарч ажилласан ажлын гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 1. 2023 оны 3 дугаар сард олон улсын нисэх буудалд бичиг баримтын зөрчилтэйн улмаас нэвтрэх, цаашид аль нэг улс руу явах боломжгүй болсон ОХУ-ын Халимаг улсын иргэний асуудлаар НҮБ-ын СЗГ-тай холбогдон ажиллаж, цаашид гуравдагч улс руу явах, орогнол хүсэх талаар туслалцаа үзүүлсэн. Бусад:<br>- НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан ажлын хэсгийн гишүүн Elena Steinarte-д 22 дугаар илтгэлийн 1 дүгээр бүлгийн 1 дүгээр хэсгийг 7 дугаар сарын 18-ны өдөр хүргүүлсэн.<br>- Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн дүгнэлтийг танилцуулахтай холбогдуулж 9 дүгээр сарын 18-ны | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өдөр НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлтэй холбогдож Б.Энхболд гишүүн видео мэдэгдэл хийж оролцсон хүргүүлсэн. | |
| 5.3 | Зорилт 5.3:Олон улсын болон бүс нутгийн түвшинд Хүний эрхийн Үндэсний Комиссын байр суурь, оролцоог нэмэгдүүлэх. | | | | | | |
| 5.3.1 | Арга хэмжээ 5.3.1: Бүс нутгийн болон олон улсын сүлжээ байгууллагуудтай олон талт түншлэлийг хөгжүүлэх, үйл ажиллагаанд идэвхтэй оролцох. - Ази Номхон Далайн бүс нутгийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын Чуулганы (АНДЧ) Орлогч даргын чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх. | Улсын төсөв, төсөл хөтөлбөр | Хамтарч ажилласан ажлын гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 1. Казахстан Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хүний эрхийн хорооны нарийн бичгийн дарга Абишев Тастемир Даутовичийг 2023.03.24-ний өдөр хүлээн авч уулзан хоёр улсын иргэд, бүртгэлгүй оршин суугаа казах хүүхдийн эрхийг хамгаалах, иргэний харьяаллын асуудлыг шийдвэрлэх талаар хамтран ажиллахаар тохиролцсон.<br>2. Филиппин Улсын Хүний эрхийн комиссын хүсэлтээр 2023.06.02-ны өдөр тус улсын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмын тухай хуулийг батлуулахад туршлага солилцох уулзалтыг зохион байгуулсан.<br>3. Комиссын дарга Ж.Хунан Швейцарийн Холбооны Улсын Женев хотноо 2023.03.14-нөөс 16-ны өдрүүдэд зохион байгуулагдсан ХЭҮБДХ-ны ээлжит хуралд оролцож АНДЧ-ны салбар хуралдаан болох арга хэмжээг төлөвлөхийн зэрэгцээ АНДЧ-ны дарга болох БНСУ-ын ХЭҮК-ын дарга зэрэг төлөөлөлтэй уулзалт хийж, бүс нутгийн байгууллагын харилцаан уялдаа, хамтын ажиллагааг сайжруулах, байгууллага хоорондын хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргах, харилцан айлчлах, туршлага солилцох талаар санал солилцсон.<br>4. 2023.09.20, 21-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Ази Номхон Далайн бүс нутгийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын Чуулганд (АНДЧ) Комиссын дарга Ж.Хунан Орлогч даргын статусаар оролцсон.<br>5. БНЭУ-ын Шинэ Дели хотноо 2023.09.19-нөөс 21-ний өдрүүдэд болсон Ази Номхон Далайн бүс нутгийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын Чуулганы хуралдаанд Комиссын дарга Ж.Хунан, Тамгын газрын дарга Ц.Адъяахишиг, Сургалт, сурталчилгааны хэлтсийн дарга Х.Цэцгээ нар оролцсон.<br>6. Евроазийн Омбудсмены Байгууллагуудын Дэлхийн Холбооны олон улсын 8 дугаар хурлын үеэр Комиссын гишүүн С.Дондов ОХУ, Азербайжан, Киргизстан, Тажикистан, Казакстан улсуудын Омбудсменуудтай уулзалт хийсэн.<br>7. Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллагын Хэвлэлийн эрх чөлөөний асуудал эрхэлсэн тусгай төлөөлөгчийн албаны урилгаар 2023.07.06, 07-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Киргиз Улсын Бишкек хотноо зохион байгуулагдсан “Хэвлэлийн эрх чөлөөний асуудлаарх Төв Азийн 24 дүгээр бага | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хурал, Салаа замын уулзвар дээр: Ардчиллыг хамгаалах үүднээс хэвлэлийн эрх чөлөөг манах нь” семенарт, Бүгд Найрамдах Солонгос Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Филиппин Улсын Хүний эрхийн Комиссын урилгаар 2023.08.28-наас 09.01-ний өдрүүдэд Филиппин Улсын Манила хотноо зохион байгуулагдсан “Ази, Номхон далайн бүс нутагт ахмад настнуудын хүний эрхэд дэвшил авчрах нь: Ази, Номхон далайн бүс нутгийн хүний эрхийн үндэсний байгууллагуудад ахмад настны хүний эрхийг хамгаалах, дэмжих олон улсын тогтолцоог бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх” сэдэвт семинарт комиссын төлөөлөл оролцсон. | |
| 5.3.2 | Арга хэмжээ 5.3.2: Хүний эрхийн тулгамдсан асуудлаар олон улсын арга хэмжээг Монгол Улсад зохион байгуулж, асуудлыг холбогдох талуудын оролцоотой шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх.<br>- Монгол Улс дахь олон улсын байгууллагуудтай “Тогтвортой хөгжил-Хамтын ажиллагаа” ээлжит уулзалтыг зохион байгуулах;<br>- Хүний эрхэд суурилсан хууль сахиулах болон мөрдөн шалгах ажиллагааны чадавхыг бэхжүүлэх хүрээнд НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр болон Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагад санал гаргах;<br>- Олон улсын эксперт, мэргэжилтнийг урих. | Улсын төсөв, төсөл хөтөлбөр | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 0 | 2 | 1. НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газартай хамтран "ХЭҮК, Иргэний нийгмийн түншлэл" 20 дахь уулзалтыг “Тогтвортой хөгжил-Хамтын ажиллагаа” 8 дахь ээлжит уулзалттай хамтатган 2023.06.27-ны өдөр “Иргэний орон зайн асуудал” сэдвээр Монгол Улс дахь олон улсын байгууллага, олон улсын эксперт, үндэсний олон талын төлөөллийг хамруулсан хэлэлцүүлгийг зохион байгуулсан. 2023.11.22-ны өдөр “Тогтвортой хөгжил-Хамтын ажиллагаа” 8 дахь ээлжит уулзалтыг зохион байгуулж 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй судалгаа, дүн шинжилгээ, сургалт, сурталчилгааны төслийн саналуудыг оролцсон олон улсын байгууллагууд, дипломат төлөөлөгчийн газруудад танилцуулсан.<br>2. ЕАБХАБ-ын АИХЭА-ны дэмжлэгтэйгээр 2022 оны 09 дүгээр сард жагсаал цуглааны үед хууль сахиулах тухай сэдвээр зохион байгуулсан сургалтын үр нөлөөг бэхжүүлэх үүднээс 2023 онд цагдаагийн удирдах ажилтны сургалтыг бүсчилсэн байдлаар хийхээр тохирсон. Эхний бүсчилсэн сургалтыг 9 дүгээр сард зүүн бүсэд хийх ЦЕГ-ын саналыг ЕАБХАБ-ын АИХЭА-нд хүргүүлсэн боловч ЕАБХАБ-аас төсвийн хүндрэлтэй байдлын улмаас 2024 оны эхний хагас жил хүртэл хойшлуулсан.<br>3. 2023.10.31-ний өдөр зохион байгуулагдсан "Хүний эрхийн боловсролын арга зүй симпозиум"-д Данийн хүний эрхийн институтийн Хүний эрх ба тогтвортой хөгжлийн газрын дарга Шилле Стидсэндийг оролцож Данийн Хүний эрхийн Хүрээлэнгийн боловсруулсан хүний эрхийн боловсрол судлах шинэ аргачлалыг танилцуулсан.<br>4. Олон улсын хүний эрхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагаанд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл, ХЭДКА-ны Ази Номхон далайн бүс хариуцсан секторын дарга Рори Мунговенийг оролцуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.3.3 | Арга хэмжээ 5.3.3: Хүний эрхийн чиглэлээр олон улсын хурал, сургалт, семинарт ажилтнуудыг хамруулж, бэлтгэл ажлыг хангах.<br>- Евроазийн Омбудс байгууллагуудын ээлжит хуралд Комиссын төлөөлөл оролцох;<br>- Ази Номхон Далайн бүс нутгийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын Чуулганы (АНДЧ) ээлжит хуралд Комиссын төлөөлөл оролцох;<br>- Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Дэлхийн Холбооны (ХЭҮБДХ) ээлжит хуралд Комиссын төлөөлөл оролцох;<br>- Комиссын ажилтнуудыг Флиндерсийн Их Сургуультай хамтран Австрали Улсад зохион байгуулагдах сургалтад хамруулах. | Уригч байгууллагын зардлаар | Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 1. Турк Улсын Омбудсенийн урилгаар "Хүний эрхийн ирээдүй 21 дүгээр зуунд" сэдэвт арга хэмжээнд Комиссын дарга Ж.Хунан, Гомдол, мэдээлэл шалгах хэлтсийн дарга Г.Ууганбаатар нар оролцсон.<br>2. Комиссын дарга Ж.Хунан, гишүүн С.Дондов, референт У.Чойжилсүрэн нар 2023.03.14-16-ны өдрүүдэд ШХУ-ын Женев хотноо зохион байгуулагдсан ХЭҮБДХ-ны хуралд оролцсон.<br>3. Комиссын дарга Ж.Хунан Тайландын Хаант Улсын Бангкок хотноо 2023.06.04-нөөс 10-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Азийн улс орнуудын хүний эрхийн үндэсний байгууллагуудад зориулсан “Бизнес ба хүний эрхийн хөтөлбөр” болон НҮБ-ын Хариулгатай бизнес ба хүний эрхийн асуудлаарх Ази, Номхон далайн форумд оролцсон.<br>4. Австралийн Холбооны улсын ЗГ-н тэтгэлэгээр ХЭҮК, Флиндерсийн их сургуультай хамтран "Цахим эрин дэх Монгол Улсын хүний эрхэд суурилсан хөгжлийг дэмжих нь" сэдэвт 21 хоногийн гадаад сургалтад 10 албан хаагч 2023.09.14-2023.10.09 өдрүүдэд хамрагдсан.<br>5. БНЭУ-ын Шинэ Дели хотноо 2023.09.19-21-ний өдрүүдэд болсон Ази Номхон Далайн бүс нутгийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын Чуулганы хуралдаанд Комиссын дарга Ж.Хунан, Тамгын газрын дарга Ц.Адъяахишиг, Сургалт, сурталчилгааны хэлтсийн дарга Х.Цэцгээ нар оролцсон.<br>6. Комиссын гишүүн Б.Энхболд, Я.Цэлмэн нар үний эрхийн Үндэсний Байгууллагуудын Дэлхийн Холбооны (ХЭҮБДХ)-ны олон улсын ээлжит бага хуралд оролцсон.<br>8. Комиссын гишүүн С.Дондов, ахлах мэргэжилтэн Э.Эрдэнэтөгс нар 2023.10.19-20-ны өдрүүдэд ОХУ-ын Москва хотноо зохион байгуулагдсан Евроазийн Омбудс байгууллагуудын ээлжит хуралд эмнэлгийн үйлчилгээ, туслалцаа авах эрхийн талаар илтгэл тавьж оролцсон.<br>9. Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал батлагдсаны 75 жилийн ойн хүрээнд НҮБХЭДКА-наас Швейцарийн холбооны улсын Женев хотод 12 дугаар сарын 11-12-ны өдөр зохион байгуулах Дээд хэмжээний арга хэмжээнд Комиссын төлөөлөл оролцсон. | 100 |
| МУХЭҮКТХ: 7.1.7.хүний эрхийн асуудлаар төр, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллага, хуулийн этгээд болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах; | | | | | | | |
| 5.4 | Зорилт 5.4: Иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтын ажиллагааны үр дүнтэй түншлэлийг бэхжүүлэх. | | | | | | |
| 5.4.1 | Арга хэмжээ 5.4.1: Комиссын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй | Улсын төсөв | Хэвлэл мэдээлэл, олон | 0 | 100 | 1. 2023.03.25-ны сэтгүүлчдийн клубийн уулзалтыг зохион байгуулж, Комиссын дарга, гишүүд, Тамгын газрын дарга | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | харилцах стратегийг батлуулах, хэрэгжүүлэх.<br>- “Хүний эрхийн төлөө” сэтгүүлчдийн клубийн үйл ажиллагааг эрчимжүүлэх;<br>- Комиссын явуулж буй үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, хэвлэлийн бага хурал зохион байгуулах, ярилцлага өгөх ажлыг хэрэгжүүлэх. | | нийттэй харилцах стратегийн хэрэгжилтийн хувь | | | Ц.Адъяахишиг нар 25 сэтгүүлчдэд Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийг бүлэг тус бүрээр нь танилцуулсан. 2023.06.09-ний өдөр зохион байгуулсан сэтгүүлчдийн клубийн уулзалт, сургалтад нийт 14 хэвлэл мэдээллийн байгууллагын 15 сэтгүүлч хамрагдсан. АББД-аас урьдчилан сэргийлэх нь сургалтыг “Хүний эрхийн төлөө сэтгүүлчид” клубын сэтгүүлчдэд зохион байгуулсан. Сургалтад ХЭҮК-ын гишүүн Х.Мөнхзул, “Эмэгтэй удидагч сан” тэргүүн М.Болормаа, Хэвлэл, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн Г.Нацаг-Эрдэнэ сургалт, мэдээлэл хийсэн. Сургалтад 23 сэтгүүлч хамрагдсан.<br>2023.11.02-нд “Хүний эрхийн түгээмэл Тунхаглал-75, Хүний эрх хамгаалагчдын тухай Тунхаглал-25” сэдвээр сургалт зохион байгуулсан. Тус сургалтад нийт 14 сэтгүүлч хамрагдаж, Тунхаглалын агуулгыг олон нийтэд таниулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахаар тохирсон. Энэ хүрээнд нийт 15 контент, ярилцлага бэлтгэж, хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр түгээж, сурталчилсан.<br>2023.11.11-ний өдөр Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран “Хүний эрхийн түгээмэл Тунхаглал-75 ба Албадан хөдөлмөр эрхлэлт” сургалт зохион байгуулан ХЭТТ болон ХЭХТТ-ын талаар танилцуулж, “1 сэтгүүлч-1 бүтээл” хөтөлбөрт хамрагдах сэтгүүлчдийг бүртгэсэн. Сургалтад Комиссын дэргэдэх клубын сэтгүүлчид болон “Засаглалд залуусын хяналт” ТББ, “Мэдрэмжтэй мэдээлье” клубын нийт 32 сэтгүүлч хамрагдсан.<br>2. Олон нийттэй харилцах стратегийг боловсруулж, Комиссын гишүүн Г.Нарантуяад танилцуулсан.<br>3. Тайлант хугацаанд Комиссын сайт, пэйж хуудаст 328 мэдээ, мэдээлэл болон 124 видео мэдээлэл бэлтгэж, оруулан олон нийтийн сүлжээгээр сурталчилсан. | |
| 5.4.2 | Арга хэмжээ 5.4.2: Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 75 жилийн ой, Хүний эрхийн олон улсын өдрийг батлагдсан төлөвлөгөөний дагуу тэмдэглэн өнгөрүүлэх. | Улсын төсөв, төсөл хөтөлбөр | Дэд төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 0 | 100 | Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 75 жилийн ойн төмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөө гарган ажиллав.<br>- “Хүний эрхийн форум 2023” зохион байгуулав.<br>- ХЭТТ-ыг сурталчилсан контент бүтээлгэн олон нийтэд түгээв.<br>- “ХЭТТ манай ангид” уриалга, ая зохион байгуулав.<br>- ХЭТТ 75 жилийн ойн тэмдэг хийж, ойн лого бүхий сурталчилгаа, сургалт гарын авлагад байршуулав.<br>- “Хүний эрх хамгаалагчдад зориулсан хууль тогтоомжийн эмхэтгэл” өврийн номыг 2000 хувь хэвлүүлж, олон нийтэд түгээв.<br>- Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд ойн төгөл байгуулав. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.4.3 | Арга хэмжээ 5.4.3: ЦЕГ-тай хүний эрх хамгаалагчийг хамгаалах асуудлаар хамтын ажиллагааг бэхжүүлж, Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн алба хаагчдыг чадавхжуулах чиглэлээр хамтран ажиллах. | Улсын төсөв | Хамтран ажилласан ажлын гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 2023.09.08-ны өдөр ХЭҮК-ын дэргэдэх орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хорооны гишүүд, ХЭХХ-ийн ажилтнууд, ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн алба хаагчид, Хүний эрхийн форумын дэргэдэх Хүний эрхийн зөрчилд шуурхай хариу үзүүлэх тусгай төсвийн гишүүдийг оролцуулан 16 оролцогчтойгоор зохион байгууллаа. Сургалтыг хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн гомдол, мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх, гомдол, мэдээллийн талаар нотолгоо, баримт, мэдээлэл цуглуулах, хүний эрх хамгаалагчид учирсан аюул, эрсдэлийн үнэлгээг хийх, ХЭХХ-ны дүгнэлт гаргах чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор Монголын эмэгтэйчүүдийн сан дэмжиж, “Оюутолгойн хяналт” ТББ-тай хамтран зохион байгууллаа. “Аюулын зэрэг тогтоох, эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал” сургалтыг ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэстэй хамтарч ажиллах хүрээнд 3 иргэний аюулгүй байдлыг хангуулахаар хамгаалалтын асуудлыг шийдвэрлүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. | 100 |
| 5.4.4 | Арга хэмжээ 5.4.4: Хүний эрх хамгаалагчдын эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг өмгөөлөгчдийг чадавхжуулах. | Улсын төсөв | Хамтран ажилласан ажлын гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Хууль зүйн туслалцааны төв, Монголын Өмгөөлөгчдийн холбоотой хамтран 21 аймгийн 9 дүүргийн өмгөөлөгч нарт нийт 3 удаагийн танхим болон цахимаар хосолсон сургалтыг зааж, нийт 75 өмгөөлөгчийг “Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт сургалтад хамруулав. ХЭҮК-оос Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлэхэд өмгөөлөгч, хүний эрх хамгаалагчдын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор “Хүний эрх хамгаалагч ба өмгөөлөл” сургалтыг “ЛГБТ Төв” Төрийн бус байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр хамтран 2023.09.27-ны өдөр зохион байгуулсан. Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгчид, Хүний эрхийн чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудын 20 төлөөлөл уг сургалтад хамрагдсан.<br>Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлэхэд өмгөөлөгч, хүний эрх хамгаалагчдын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор “Хүний эрх хамгаалагч ба өмгөөллийн үйл ажиллагаанд анхаарах зарим асуудал” сургалтыг ХЭҮК, “ЛГБТ төв” ТТБ-тай хамтран 2023.11.17-ны өдөр зохион байгуулсан.<br>Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгчид, Хүний эрхийн форумын дэргэдэх Хүний эрхийн зөрчилд шуурхай хариу үзүүлэх тусгай төсвийн гишүүд болон иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл хамрагдсан уг сургалтад ХЭҮК-ын Хүний | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүн С.Дондов, Комиссын дэргэдэх Хүний эрх хамгаалагчийн хорооны гишүүн Л.Баасанжав, Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч Л.Отгондорж, “ОюуТолгойн хяналт” ТББ-ын тэргүүн Д.Сүхгэрэл нар<br>- Хүний эрх хамгаалагчийг хамгаалах хэүк-ын үйл ажиллагаа,<br>- ЛГБТ хүний эрх хамгаалагчид-онцлог, бэрхшээл, анхаарах асуудал,<br>- Байгаль орчин дахь хүний эрх хамгаалагч-онцлог бэрхшээл, анхаарах асуудал зэрэг хүний эрх хамгаалагч, өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагааны онцлог, анхаарах асуудал сэдвийн хүрээнд хичээл зааж, сургалт оролцсон 20 өмгөөлөгчийн хүний эрхийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлсэн. | |
| 5.4.5 | Арга хэмжээ 5.4.5: Хүний эрх хамгаалагчийг хамгаалах талаар аж ахуйн нэгж, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд тусгах асуудлаар заавар, зөвлөмж гарган МҮЭХ-той хамтран сурталчилгаа, нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэх. | Улсын төсөв | Нөлөөллийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | Хүний эрх хамгаалагчийн үйлдлийг хамгаалах зохицуулалтыг байгууллагын дотоод журамд тусгаж, хэрэгжилтийг хангах, сургалт зохион байгуулах үүргийг хэрэгжүүлэх аргачлалыг боловсруулж, НҮБ-ын ХЭДКГ-т орчуулан хүргүүлж санал авсан. Уг аргачлалыг хэвлүүлэн 2024 онд олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна. | 100 |
| 5.4.6 | Арга хэмжээ 5.4.6: Батлан хамгаалах яам, Үндэсний статистикийн хороо, ЦЕГ, Дотоод хэргийн их сургууль, Хуульчдын холбоо, МҮОНРТ, Баянзүрх дүүргийн Прокурорын газар, Тэгш тусгал ТББ болон, бусад байгууллагуудтай байгуулсан санамж бичиг, хамтын ажиллагааны гэрээг дэд төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах. | Улсын төсөв | Дэд төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 0 | 100 | - Батлан хамгаалах яамтай байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд Зэвсэгт хүчний Жанжин Штабын харьяа Зэвсэгт хүчний 339, 256, 017, 120 дугаар ангиудад хяналт шалгалт хийж, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Энэ хүрээнд Батлан хамгаалах яамны сайд Г. Сайханбаярт 2023.10.30-ны өдрийн 06/57 дугаартай зөвлөмж хүргүүлсэн.<br>- Баянзүрх дүүргийн Прокурорын газрын Ерөнхий Прокурорын орлогч прокурор хууль цаазын итгэмжит зөвлөх Б.Батбаяр, ХЭҮК-ын Тамгын газрын дарга Ц.Адъяахишиг нар “Нийтийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр хамтран ажиллах төлөвлөгөө”-г байгуулсан.<br>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай 2023.05.15-ны өдөр, Монголын Өмгөөлөгчдийн холбоотой 2023.11.08-ны өдөр хамтран ажиллах санамж бичиг тус тус байгуулсан.<br>- Цагдаагийн Ерөнхий газартай санамж бичгийг байгуулахаар бэлтгэл ажил хангасан. Санамж бичиг бүхий байгууллагуудтай 2023 онд хамтран ажилласан тайланг нэгтгэж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.4.7 | Арга хэмжээ 5.4.7: Иргэний нийгмийн зөвлөлийн үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх. | Улсын төсөв | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 0 | 100 | Иргэний нийгмийн зөвлөлийн 2023 он үйл ажиллагааны төлөвлөгөөнд 5 зорилт, 16 арга хэмжээг тусгаж, хэрэгжилтийг хангаж ажилласан ба биелэлтийн нэгтгэн гаргасан. Иргэний нийгмийн зөвлөлийн хуралдааныг 02.03-ны өдөр, 04.07-ны өдөр, 10.19-ний өдөр, 12.20-ны өдөр буюу нийт 4 удаа зохион байгуулсан.<br>“Иргэний нийгмийн түншлэл" 20 дахь уулзалтыг “Тогтвортой хөгжил-Хамтын ажиллагаа” 8 дахь ээлжит уулзалттай хамтатган 2023.06.27-ны өдөр “Иргэний орон зайн асуудал” сэдвээр Монгол Улс дахь олон улсын байгууллага, олон улсын эксперт, үндэсний олон талын төлөөллийг хамруулсан хэлэлцүүлгийг зохион байгуулав.<br>Иргэний нийгмийн зөвлөлийн гишүүдээс “Иргэний нийгмийн байгууллагын эрх зүйн зохицуулалт” баримт бичигт санал авч, саналыг нэгтгэж ажилласан. Мөн Газрын багц хууль, Гэр бүлийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хууль, Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн төслүүдэд санал авч хүргүүлсэн.<br>Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан “Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого”-ын төслийн хэлэлцүүлэгт Иргэний нийгмийн зөвлөлийн гишүүдэд холбогдох баримт бичгийн төслийг хүргүүлж, хэлэлцүүлэгт оролцуулсан. “Иргэний нийгмийн зөвлөлийн гишүүнд урамшуулал олгох журам”-ыг 2023.09.29-ний өдрийн Комиссын даргын А/26 дугаар тушаалаар баталсан. ИНЗ-ийн гишүүдийн Комисстой хамтран ажилласан цагийн тооцооллыг гаргаж 3,218,503 /гурван сая хоёр зуун арван найман мянга таван зуун гурван/ төгрөгийн урамшуулал олгосон.<br>Олон улсын хүний эрхийн өдрөөр Иргэний нийгмийн зөвлөлийн гишүүн Л.Очирбал, Д.Арвинтариа, Б.Ардак нарыг ХЭҮК-ын "Хүний эрхийн төлөө" хүндэт тэмдгээр тус тус шагнасан. | 100 |
| Стратегийн зорилго зургаа. Хүний эрхийн үндэсний комиссын чадавхыг бэхжүүлэх | | | | | | | |
| Алсын хараа 2050: 5.5.3.Хүний эрхийн Үндэсний Комисс хараат бусаар үйл ажиллагаа явуулж, чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх нөхцөлийг хангаж, үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэнэ. | | | | | | | |
| 6.1 | Зорилт 6.1: Комисс нь иргэдэд нээлттэй, ил тод, хүртээмжтэй, хүрэлцээтэй үйл ажиллагаагаа явуулах байртай болох. | | | | | | |
| 6.1.1 | Арга хэмжээ 6.1.1: Комиссын байр барих газар, хөрөнгийг шийдвэрлүүлэх.<br>- Байр барих газрын зөвшөөрөл | Улсын төсөв, төсөл хөтөлбөр | Байртай болоход чиглэсэн | 0 | 100 | 1. Засгийн газрын 2023.03.29-ний өдрийн 109 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023.03.21-ний өдрийн 102 дугаар тогтоолоор Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хөрөнгөнд бүртгэлтэй нийт 1,507,268,176,00 төгрөгийн | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | авах талаар холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэх;<br>- Барилгын зураг, төсөв боловсруулах, төсвийн асуудлыг шийдвэрлүүлэх;<br>- “Хүний эрхийн төгөл” цогцолборын зураг, төсөв боловсруулах. | | нөлөөллийн ажлын хувь | | | балансын үнэ бүхий Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хорооны нутагт байрлах биет бус хөрөнгө (2645 м.кв газар эзэмших)-ийг хашааны хамт Хүний эрхийн Үндэсний Комисст балансаас балансад шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Нийслэлийн Засаг даргын 2023.03.23-ны өдрийн А/286 дугаар захирамжаар Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хорооны нутагт байрлах 2645 м.кв газрыг Хүний эрхийн Үндэсний Комисст эзэмшүүлсэн.<br>2.Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1621 тоот захирамж гаргаж, Хүний эрхийн үндэсний комисст 20000 ам.метр талбай эзэмших эрхийг олгосон.<br>3.Комиссын байр барих газрын асуудлыг шийдвэрлүүлж, барилгын ажлын архитектур төлөвлөлтийн даалгавар гаргуулах хүсэлтийг Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газарт хүргүүлсэн.<br>4.Барилгын зураг, төслийг Урбанвижин ХХК-иар гүйцэтгүүлж Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газарт Архитектур төлөвлөлтийн даалгавар авах хүсэлтийг дахин 2023.05.10-ны өдрийн ТГ-01/768 тоот албан бичгээр хандаж хариуг хүлээн авсан. Уг А даалгаварт эзэмшил газрын 1/3 хэсэгт 8*14мкв хэмжээтэй барилга барих боломжтой гэсэн ч төлөвлөгдөөд буй авто зам, дулааны шугамын асуудлаар Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Авто замын хөгжлийн газар, Газрын алба, Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх төсөл хөтөлбөрийн газруудад албан бичиг хүргүүлж, мэдээлэл солилцох уулзалт зохион байгуулсан.<br>5. Комиссын 2024 оны төсвийн төсөл, 2025-2026 оны төсвийн төсөөлөлд 8 тэрбум төгрөгийг төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлэхээр хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системээр болон Сангийн яаманд 2023.05.31-ний өдрийн 01/690 дугаартай албан бичгээр хүргүүлсэн боловч дараа жилийн төсвийн төсөлд барилга барих асуудлыг эхлээд ТЭЗҮ хийлгэх шаардлагатай гэж үзэн Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар дэмжигдээгүй. | |
| 6.2 | Зорилт 6.2: Хүний эрхийн хяналт, шалгалт, гомдол шийдвэрлэх, хүний эрхийн зөвлөгөө өгөх үйл ажиллагааг боловсронгуй болгох. | | | | | | |
| 6.2.1 | Арга хэмжээ 6.2.1: Хяналт шалгалт, Сургалтын үйл ажиллагааны журмуудыг боловсруулах. | Улсын төсөв, төсөл хөтөлбөр | Боловсруулсан журмын тоо | 0 | 2 | 1. “Хяналт шалгалтын журам”-ыг шинээр боловсруулж Комиссын гишүүдийн саналыг тусган Комиссын даргын хяналтад шилжүүлсэн.<br>2. Хүний эрхийн сургалт зохион байгуулах журмын төслийг боловсруулах ажлын явц 85%- тай байгаа бөгөөд ISO 9001:2015 | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Чанарын менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлж байгаатай уялдуулан өөрчлөлт хийхээр болсон. | |
| 6.2.2 | Арга хэмжээ 6.2.2: Жагсаал, цуглаан, нийтийн хамарсан онцгой нөхцөл байдалд Комиссын ажиллах журмыг боловсруулах, хэрэгжүүлэх бэлтгэх ажлыг хангах. | Улсын төсөв, төсөл хөтөлбөр | Боловсруулсан журмын тоо | 0 | 1 | Журмын төслийг боловсруулах ажлыг судлаачаар гүйцэтгүүлэн Комиссын гишүүдэд хүргүүлэн, санал авч эцсийн хяналтыг Г.Нарантуяа гишүүн хийж байна. Комиссын ээлжит бус хуралдаанд танилцуулж батлуулахаар бэлтгэж байна. | 90 |
| 6.2.4 | Арга хэмжээ 6.2.4: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ба хүний эрхийн чиглэлээр Комиссын алба хаагчдыг чадавхжуулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх. | Улсын төсөв, төсөл хөтөлбөр | Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 1. "Халдашгүй чөлөөтэй байх эрх" сэдвээр Комиссын гишүүн Б.Энхболд Тамгын газрын нийт албан хаагчдад дотоодын сургалт зохион байгуулж, орон нутгийн албан хаагчид цахимаар хамрагдсан.<br>2. Хүн худалдаалах гэмт хэргийн ойлголт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын болон үндэсний эрх зүйн зохицуулалт, Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй мөрдөн шалгах ажиллагаа, Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх тусламж, үйлчилгээ, Цахим зохион байгуулалттай хүн худалдаалах гэмт хэрэг сэдвүүдээр Азийн сангийн дэмжлэгтэйгээр ЦЕГ, ДХИС, НПГ зэрэг байгууллагуудтай хамтран Тамгын газрын болон орон нутгийн албан хаагчдыг хамруулсан сургалт 2023.06.28-ны өдөр зохион байгуулсан. | 100 |
| 6.2.5 | Арга хэмжээ 6.2.5: Комисст иргэдээс ирүүлсэн гомдлын шийдвэрлэлтийг хянах, олон нийтэд мэдээлэх цахим систем хэрэглээнд нэвтрүүлж мэдээллийн сан байгуулах. | Улсын төсөв | Мэдээллийн сангийн тоо | 0 | 1 | 1. Комиссын цахим хуудас шинэчлэгдэж байгаатай холбоотойгоор гомдол, мэдээллийг цахимаар хүлээн авах нэмэлт цэстэй болсноор иргэдэд чирэгдэлгүй, түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх аятай нөхцөл бүрдэж, иргэд өөрийн гаргасан гомдлын талаар шалгах бүрэн боломжтой болсон.<br>2. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу хүний эрх хамгаалагчийн талаарх гомдол мэдээллийн сантай байх чиг үүргийн хүрээн Гомдол мэдээллийн сангийн журмын төслийг боловсруулан, орчуулж НҮБ-ын ХЭДКГ-т хүргүүлсэн.<br>Уг журамд 2024 оны 1 сард санал ирүүлж, гомдол мэдээллийн сангийн цахим талбар бүрдүүлэхэд хамтран ажиллах, төсвийг гаргахаар тохиролцсон.<br>Мөн Комиссын нэгдсэн мэдээллийн сан байгуулах систем хийлгэх талаар судалж үнийн санал авсан бөгөөд энэ оны байгууллагын төсөв хүрэлцэхгүй тул хойшилсон. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6.2.6 | Арга хэмжээ 6.2.6: ХЭҮК-ын гомдол шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийх. | Улсын төсөв, төсөл хөтөлбөр | Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход чиглэсэн үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | Комиссын даргын 2023.03.03-ны өдрийн А/08 дугаар тушаалаар Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн тухай гомдол, мэдээллийг шийдвэрлэх ажиллагааны журмыг шинэчлэн баталсан бөгөөд үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 4, 5 дугаар бүлэгт тусгасан зохицуулалтыг заалт бүрийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийж, тодруулах шаардлагатай асуудлуудыг судалж байна. Дүн шинжилгээний ажилтай холбоотой Төрийн болон албаны нууцын тухай, Шүүхийн шинжилгээний тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Прокурорын тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай, Зөрчлийн тухай, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт, уялдаа холбоонд дүн шинжилгээ хийж байна. | 70 |
| 6.3 | Зорилт 6.3: Хүний эрхийн Үндэсний Комиссын материаллаг болон мэргэжлийн чадавхыг бэхжүүлэх. | | | | | | |
| 6.3.1 | Арга хэмжээ 6.3.1: Албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах хөтөлбөрийг шинэчилж, хэрэгжилтийг хангах. | Улсын төсөв, төсөл хөтөлбөр | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 0 | 100 | Дотоод журамд заасан буцалтгүй тусламж, дэмжлэг олгосон байдал:<br>1. Шинэ төрсөн хүүхэдтэй 5 ажилтанд нийт 2,500,000 төгрөг, гэр бүлийн гишүүн нь нас барсан 8 ажилтанд нийт 4,500,000, удаан хугацаагаар эмчлүүлж байгаа, хагалгаанд орсон 5 ажилтанд нийт 8,500,000 сая төгрөгийн, гэр бүлийн хүн нь удаан хугацаагаар эмчлүүлж байгаа 5 ажилтанд нийт 4,600,000 төгрөгийн буцалтгүй тусламж, Тамгын газрын 1 ахмад настанд түлээ нүүрсний тусламж болгон 300.000 төгрөг, 5 албан хаагчид 500,000 төгрөг тус тус олгосон байна.<br>2.Гадаад улсад удаан хугацаагаар суралцахаар болж төрийн албанаас түр чөлөөлөгдсөн 2 албан хаагчид албан тушаалын 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний нийт 12.3 сая төгрөг, 1 ажилтанд 1 сарын цалинтай тэнцэх хэмжээний 1,3 сая төгрөгийн нөхөх төлбөр олгосон.<br>3.Төрийн албаны мэргэшүүлэх сургалтад хамрагдаж байгаа 5 албан хаагч болон гадаад сургалтад хамрагдаж байгаа 9 албан хаагчид Тамгын газрын даргын тушаалаар цалинтай чөлөө олгосон.<br>4.Сар шинийн баяр, Ахмадын баярын өдрийг тохиолдуулан Комиссын ахмадад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.<br>5."Рехамед" эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээний хүрээнд урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг, үзлэг, оношилгоонд 71 албан хаагч хамрагдсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 6.Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор байгууллага дээр гэрээт эмч ажиллуулж эхэлсэн.<br>7.Эцэг эхийн зөвлөлөөс байгууллагын албан хаагчдын хүүхдийн өрөөг тохижуулж шинээр байгуулав.<br>8.Тамгын газрын даргын 2023.03.10-ны өдрийн А/22 дугаар тушаалаар албан хаагчдын 2023 оны ээлжийн амралтын хуваарь баталж, хуваарийн дагуу нийт 73 албан хаагч бүрэн биеэр эдэлж, амарсан<br><br>Төрийн албан хаагчийн нөхөх төлбөр олгосон байдал:<br>1. Тамгын газрын даргын 2023.03.31-ний өдрийн А/25 дугаар тушаалаар хоолны мөнгийг 19,000 болгож, хоол унааны хөнгөлөлтийг 1 дахин нэмэгдүүлсэн.<br>2.Хүний эрх, эрх чөлөөний байдлын 22 дахь илтгэл, Комиссын байрны нүүлгэлтийн ажил, “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2023” арга хэмжээ, “Ярьдаг футболк 2023” хүний эрхийн өдөрлөг, Үндэсний их баяр наадмын өдрүүд, үерт өртсөн иргэдийн хүний эрхийн нөхцөл байдалд ажиглалт, дүн шинжилгээ хийх, Комиссын 2024 оны төсвийн төслийг эцэслэх, барилгын газрын асуудлаар баримт мэдээлэл боловсруулах, "Манай ангид хүний эрхийн Түгээмэл тунхаг" оюутан сурагчдын хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх аян, архивын баримт цэгцлэх, Хүний эрхийн боловсролын арга зүй” симпозиум, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад зориулсан хүний эрхийн сургагч багш бэлтгэх сургалт, Иргэний нийгмийн зөвлөл, Хүний эрх хамгаалагчийн хорооны гишүүдийг чадавхжуулах сургагч багшаар бэлтгэх сургалтууд, Зэвсэгт хүчний Жанжин штабын харьяа 326 дугаар ангид хяналт шалгалт хийх, Хүний эрхийн үндэсний форумын бэлтгэл ажил зэрэг нийтийг хамарсан, зохион байгуулалттай арга хэмжээний үеэр баяр, ёслол, амралтын өдрүүд, ажлын бус цагаар ажилласан албан хаагчдад илүү цагийн хөлс олгосон.<br>Төрийн албан хаагчийн цалин хөлс нэмэгдүүлсэн байдал:<br>1.Тамгын газрын даргын 2023.01.18-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар төрийн үйлчилгээний 8 албан хаагчдын цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоож, 2023.03.14-ний өдрийн А/21 дүгээр тушаалаар албан тушаалын цалингийн хэмжээг 20 хувиар нэмэгдүүлж, төрийн захиргааны 2 албан хаагчийн цалингийн шатлал ахиулсан.<br>2.Тамгын газрын даргын 2023.01.18-ны өдрийн А/03 дугаар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тушаалаар төрийн захиргааны болон үйлчилгээний нийт 63 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгосон.<br>3.Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэсэн 1 албан хаагчид сар бүр орлон ажиллаж байгаа албан тушаалын цалингийн 40 хувийн нэмэгдэл, 3 сар орлон ажилласан 1 албан хаагчид 20 хувийн нэмэгдэл 1 удаа олгосон.<br>4.Комиссын даргын 2023.01.18-ны өдрийн А/02 дугаар тушаалаар төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв 4 албан хаагчид шинээр, 6 албан хаагчид ахиулан олгосон.<br>5.МУ-ын Ерөнхийлөгчийн 2023.02.06-ны өдрийн 09 дүгээр зарлигаар Комиссын 2 гишүүнд шинээр дэд түшээ зэрэг дэв, Ерөнхий сайдын захирамжаар 3 албан хаагчид эрхэлсэн түшмэлийн дөтгөөр зэрэг дэв тус тус олгосон.<br>6.Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг Тамгын газрын даргын 2023.10.03-ны өдрийн А/105 дугаар тушаалаар 25 хувиар нэмэгдүүлсэн.<br>7.Төрийн үйлчилгээний 2 ажилтанд Тамгын газрын даргын 2023.10.09-ний Б/95 дугаар тушаалаар ур чадварын нэмэгдэл ахиулан 25 хувиар олгосон.<br>8.Тамгын газрын даргын 2023.10.17-ны А/107 дугаар тушаалаар албан хаагчдад 3 дугаар улирлын ажлын гүйцэтгэлийн үнэлгээний дагуу А үнэлгээнд албан тушаалын цалингийн 40 хувь, В үнэлгээнд 30 хувийн мөнгөн урамшуулал тус тус олгосон. | |
| 6.3.2 | Арга хэмжээ 6.3.2: Комиссын алба хаагчдын сургалтын төлөвлөгөө боловсруулж, төлөвлөгөөний дагуу чадавхыг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулах. | Улсын төсөв, төсөл хөтөлбөр | Мэргэшсэн, чадварлаг хүний нөөц бүрдүүлсэн байдал | 0 | 100 | 1.Төрийн албаны мэргэшүүлэх сургалт: Төрийн албаны тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2, эрхэлсэн түшмэлийн багц сургалтад 6, ахлах түшмэлийн багц сургалтад 8, төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтад 4 албан хаагч тус тус хамрагдсан.<br>2.Ажлын байрны мэргэшүүлэх сургалт:<br>- МҮЭ-ны дэргэдэх Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад 2 албан хаагчийг хамруулж гэрчилгээ олгосон.<br>- Хүний эрхийн бүх төрлийн контент бэлтгэх, түгээх чиглэлээр мэдлэг олгох “Adobe Premiere Pro” сэдэвт Эхлэл академийн 4 сарын сургалтад 1 албан хаагчийг хамруулсан.<br>- Австралийн Холбооны улсын ЗГ-н тэтгэлгээр ХЭҮК, Флиндерсийн их сургуультай хамтран "Цахим эрин дэх Монгол Улсын хүний эрхэд суурилсан хөгжлийг дэмжих нь" сэдэвт 21 хоногийн гадаад сургалтад 8 албан хаагч2023.09.14-2023.10.09 өдрүүдэд хамрагдсан.<br>3.Хүний эрхийн чиглэлээр мэргэшүүлэх бусад сургалтууд: "Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэндийн судалгаа"-ны мэдээлэл цуглуулах ажилтнуудад зориулсан 2 өдрийн сургалтад 2, мэдээллийн технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээний эрх зүйн орчны талаар мэдлэгийг эзэмшүүлэх, практикт үүсэж буй тулгамдсан асуудлыг шийдвэрлэж буй арга зам, сайн туршлагын талаарх мэдээлэл олгох “Эрх зүй ба технологи-Модуль II” сургалтад 1, Улсын Их Хурлын Тамгын газраас Монголын Хуульчдын холбоо, Швейцарын хөгжлийн агентлагтай хамтран зохион байгуулж буй Хуулийн төсөл боловсруулагчдын сургалтад 1, Олон улсын хувийн эрх зүйн Гаагийн бага хурал болон түүний конвенцууд, тэдгээрийн НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцтэй холбогдох талаар сургалтад 1, Нийгмийн шударга ёсыг бэхжүүлье, Хүүхдийн хөдөлмөрийг устгая! Бодлогын зөвлөгөөний хагас өдрийн хөтөлбөрт 1 албан хаагч, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг сурталчлах, таниулах сургагч багш бэлтгэх сургалтад байгууллагаас 5 албан хаагч тус тус хамрагдсан.<br>4. Бусад сургалтууд:<br>- Удирдлагын академиас зохион байгуулсан төрийн байгууллагуудын хүний нөөцийн ажилтнуудын чадавхыг дээшлүүлэх 2 өдрийн сертификаттай сургалтад Хүний нөөц хариуцсан референт хамрагдсан.<br>- "Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө (2023-2027)"-г танилцуулах сургалтад нийт 51 албан хаагч тус тус оролцсон.<br>- Монгол бичгийн хичээл 7 хоног бүрийн Лхагва, Баасан гарагт хичээллэж байна.<br>- Байгууллагын хэмжээнд "Чанарын удирдлагын тогтолцоо" /ISO9000:2015, ISO 9001:2015 / нэвтрүүлэх төслийн хүрээнд албан хаагчдад энэ чиглэлээр мэдлэг, ойлголт өгөх сургалтыг 7 хоног бүрийн Даваа гарагт 8.30 минутаас зохион байгуулж эхэлсэн. Тайлант хугацаанд нийт 9 удаа зохион байгуулагдсан бөгөөд орон нутгийн албан хаагчид цахимаар хамрагдаж байна. | |
| 6.3.3 | Арга хэмжээ 6.3.3: Төвлөрсөн суурин газар Комиссын албан хаагчдын орон тоог үе шаттай нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн ажлыг үе шаттай хэрэгжүүлэх. | Улсын төсөв | Албан хаагчдын тоо | 71 | 75 | 1. Адил төрлийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа орон нутаг дахь албан хаагчдын албан тушаалын зэрэглэлийг ялгаатай тогтоосон байдлыг Төрийн албаны тухай хууль болон холбогдох дүрэм, журамд нийцүүлж, Ахлах түшмэлийн ангиллын “АА-7” зэрэглэлийн “Ахлах шинжээч”-ийн албан тушаалыг “АА-6” зэрэглэлийн “Референт”-ийн албан тушаал болгон, Захиргаа удирдлагын хэлтсийн Орон нутаг дахь Референт 21 болгож | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өөрчилсөн.<br>2. 2023 онд батлагдсан төсөвт багтаан Тамгын газрын нийт орон тоог 10-аар нэмэгдүүлж 82 орон тоонд багтааж, холбогдох албан хаагчдыг томилон ажиллуулж байна. | |
| 6.4 | Зорилт 6.4: Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагааг цахим шилжилтийн бодлогод нийцүүлэн хөгжүүлэх. | | | | | | |
| 6.4.1 | Арга хэмжээ 6.4.1: Хүний эрхийн номын сан, цахим номын санг баяжуулах.<br>- Номын фондыг нэмэгдүүлэх<br>- Олон нийтэд сурталчлах | Улсын төсөв | Хүний эрхийн цахим номын санг хөгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн хувь | 50 | 100 | Байгууллагаас хэвлүүлсэн сургалтын материал, ном товхимол, эмхэтгэлүүд болон холбогдох бусад байгууллагаас ирүүлсэн ном товхимлыг цахим каталогт байршуулан бүртгэлжүүлж байна. Үүнд:<br>- Хүүхдийн хөдөлмөрийн чанарын судалгаа<br>- "Шийдвэр гаргалтын түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо" судалгааны хураангуй<br>- "Хүний эрх" онол арга зүйн сэтгүүл 2022/02<br>- Шударга ёс онол, аргазүй, мэдээллийн хагас жил тутмын цврал 2022/01 (23)<br>- Focus-Asia Pacific Хүний эрхийн мэдээллийн төвийн сэтгүүл<br>- Эрүүл мэндийн салбар дахь хүний эрхийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлан<br>- "Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилтийг хохирогч төвтэй хандлагын үүднээс үнэлэх нь" судалгааны товч тайлан<br>- Дүрвэгсдийн шилжилт хөдөлгөөн ба Монгол Улсын аюулгүй байдал" сэдэвт эрдэм шинжилгээний 3 эмхэтгэлийг номын сангийн баяжилтад авсан. | 100 |
| 6.4.2 | Арга хэмжээ 6.4.2: Дэвшилтэд техник, технологид суурилсан хүний эрхийн сургалт, судалгааны хэрэглэгдэхүүнийг нэвтрүүлэх.<br>- Хүний эрхийн сургалтын цахим платформыг шинэчлэн хөгжүүлэх. | Улсын төсөв төсөл хөтөлбөр | Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | Хүний эрхийн сургалтын цахим платформыг шинэчлэн, хөгжүүлэх ажлыг Комиссын төсөв, санхүүжилтээс хамааран хойшлуулсан. | - |
| ХОЁР. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА | | | | | | | |
| 7 | Зорилт 7: Комиссын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, төсвийн удирдлагын үр ашигтай байдлыг хангах, төрийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх. | | | | | | |
| 7.1 | Арга хэмжээ 7.1: Комиссын үйл ажиллагааны стратеги | Улсын төсөв | Үйл ажиллагааны | 0 | 100 | 1. Комиссын үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг шинэчилж Комиссын даргын А/19 дүгээр тушаалаар батлуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөөг шинэчилж, гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, тайлагнах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүнг удирдлагад танилцуулж, холбогдох арга хэмжээ авах.<br>- Сар, улирал, жилийн онцлох ажлын мэдээ бэлтгэж, олон нийтэд сурталчлах;<br>- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанд улирал, жилийн тайлан, мэдээлэл;<br>- Үндэсний хөтөлбөрүүдийн тайланг тухай бүр нь хүргүүлэх. | | гүйцэтгэлийн хувь | | | Комиссын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах арга хэмжээний саналыг Комиссын дарга, гишүүд, хэлтэс, тасгийн дарга нараас авч, тодорхой үе шаттайгаар хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан. Ирсэн санал, хэлэлцүүлгээс гарсан саналыг нэгтгэн тусгаж 2023.01.05-ны өдөр гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулсан.<br>Комиссын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан сар бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтийг хангуулан биелэлтийг Комиссын хуралдаанд тайлагнаж ажилласан. Комиссын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн эхний хагас жил, 3 дугаар улирлын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэсэн. Комиссын 2023 оны 1-12 сарын инфографик статистик мэдээллийг нэгтгэн олон нийтэд сурталчилж, 1-р улирлын болон 1-5 сарын онцлох ажлын видео мэдээ, 4 сарын онцлох мэдээллийг инфографик, постер хэлбэрээр гаргаж Комиссын фейсбүүк цахим хуудаст байршуулан олон нийтэд түгээсэн.<br>2. “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-т тусгагдсан Комиссоос хэрэгжүүлэх арга хэмжээний 2018-2022 оны 5 жилийн тайлан, 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хагас, бүтэн жилийн тайланг ХЗДЯ-нд хүргүүлсэн.<br>Жендэрийн үндэсний хорооны 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд Комиссоос хариуцан хэрэгжүүлсэн ажлын тайлан, ЖҮХ-ны 2021-2023 онд хэрэгжүүлсэн онцлох үйл ажиллагааны тайланг ЖҮХ-нд хүргүүлсэн. | |
| 7.2 | Арга хэмжээ 7.2: Хүний эрхийн асуудлаар төр, хуулийн этгээд, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах замаар дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх. | Улсын төсөв | Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | Комиссын гишүүн С.Дондов, Х.Мөнзул нарын "Талита Ази" НҮТББ-тай хийсэн уулзалт, 2023.08.31-нд тус байгууллагын хамгаалах байрны үйл ажиллагаатай танилцах ажлыг зохион байгуулсан.<br>Комиссын гишүүн Б.Энхболдын санаачлагчаар Батлан хамгаалах яам болон Зэвсэгт хүчний жанжин штаб, Барилгын цэргийн холбогдох ажилтнуудтай хийсэн уулзалт, Комиссын гишүүн Г.Нарантуяагаас санаачилсан Зорчигчийн мэдээллийн төвийн удирдлагуудтай хийсэн уулзалтыг зохион байгуулсан. ХЭҮК-т хандаж ирсэн төр, иргэний нийгмийн байгууллагуудын 22 албан бичигт хуулийн хугацаанд хариу өгч, мэдээллээр хангах, уулзалт зохион байгуулах, албан бичиг хүргүүлж ажилласан. Үүнд: Сэтгэл санааны хохирогчдын холбоо НҮТББ, Шүүхийн ерөнхий зөвлөл, Монголын сүрьеэтэй тэмцэх холбоо, АНУ-ын Элчин сайдын яам, Монголын хүүхдийн ордон, Шихихутаг их | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургууль, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комисс, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын ахмадын холбоо, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам зэрэг байгууллага болно. | |
| 7.3 | Арга хэмжээ 7.3: Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, төсөл хөтөлбөр, байгууллагын дотоод үйл ажиллагаа, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд явцын болон гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөмж чиглэл өгөх. | Улсын төсөв | Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | Комиссын 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Тамгын газрын хурал болон Комиссын 6 дугаар хуралдаанд танилцуулсан. Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн тухай танилцуулах мэдээ болон Хүний эрхийн асуудлаар хийсэн судалгаа, дүн шинжилгээ, хяналт шалгалтын мэдээ, тайланг нэгтгэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд 2023.09.06-ны өдрийн ТГ 01/1104 дугаар албан бичгээр хүргүүлсэн. "Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай" Монгол Улсын Их хурлын 2021.07.07-ны өдрийн 67 дугаар тогтоолын хэрэгжилтийн хяналт,-гинжилгээ, үнэлгээ хийсэн. Мөн 21 дэх илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай" Монгол Улсын Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 49 дүгээр тогтоолын хэрэгжилтийг үнэлгээ хийж удирдлагад танилцуулав. | 100 |
| 7.4 | Арга хэмжээ 7.4: Комиссын Тамгын газрын захиргааны шийдвэр, гэрээ, дүрэм журмын эрх зүйн үндэслэлийг хангуулах, хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих. | Улсын төсөв | Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | Комиссын даргын А тушаал 35, Б тушаал 5, Тамгын газрын даргын А тушаал 120, Б тушаал 107 тус тус боловсруулж, хянаж баталгаажуулсан. Тамгын газрын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр нийт 48 гэрээ байгуулагдсан. Эдгээрээс хөлсөөр ажиллах гэрээ 3, орон нутагт ажлын байр түрээслэх гэрээ 11 байна. Комиссын үйл ажиллагаанд мөрдөж байгаа эрх зүйн хэм хэмжээний үйлчлэл дуусаж цаашид дагаж мөрдөх шаардлагагүй 17 тушаалыг хүчингүй болгосон. | 100 |
| 7.5 | Арга хэмжээ 7.5: Комиссын хэмжээнд хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийг бүртгэлжүүлж, хэрэгжилтэд хяналт тавих. | Улсын төсөв | Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | Комиссын хэмжээнд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр. Үүнд:<br>- Монгол Улсад мэргэшсэн иргэн төвтэй төрийн албыг бэхжүүлэх нь төсөл;<br>- Олон улсын Хөдөлмөрийн байгууллагатай хамтран гүйцэтгэсэн “Хоригдлын хөдөлмөрийн судалгаа” гүйцэтгэх;<br>- Монгол Улс дахь ажлын байран дахь хүчирхийлэл, дарамтын талаарх тархалтын судалгаа ба хууль, эрх зүйн хийдлийн дүн шинжилгээ;<br>- Монгол Улс дахь хүүхдийн хөдөлмөрийн чанарын судалгаа;<br>- Хүний эрхэд суурилсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ; | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - ХЭҮК-ын эрх зүйн шинэтгэлийн шилжилтийн үед дэмжих нь;<br>- Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь;<br>- “Дэмжих бүлэг болон хүний эрхийн сургалтаар туслах малчдыг чадавхжуулах нь”;<br>- Өсвөр залуу үеийнхнийг чанартай бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах бодлого, зохицуулалтын орчныг сайжруулах төсөл;<br>- Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд туслалцаа үзүүлэх нь;<br>- Хүний эрх хамгаалагчийн үндэсний механизмын чадавх нэмэгдүүлэх арга хэмжээ болно.<br>Одоогийн байдлаар НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр болон НҮБ-ын Хүн амын сангийн санхүүжилтээр 2 төсөл хэрэгжиж эхлэх шатандаа явж байна. | |
| 7.6 | Арга хэмжээ 7.6: Төрийн албаны тухай хууль тогтоомж, стандартыг хангуулах, байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг тооцож, тайлагнах. | Улсын төсөв | Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 1.Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх арга хэмжээг 2023.05.12, 12.21-ны өдөр зохион байгуулж, нийт 8 төрийн захиргааны албан хаагч хамрагдсан.<br>2.Удирдах 2, гүйцэтгэх 6 албан тушаалын тодорхойлолтын мэргэжил хэсэгт өөрчлөлт оруулах асуудлыг ТАЗ-н хурлаар хэлэлцүүлж, 2023.06.07-ны өдрийн 209 дүгээр тогтоолоор батлагдсан.<br>3.Төрийн албаны зөвлөлийн 2023.01.17-ны 01/121 тоот албан бичиг, 2023.01.11-ний өдрийн Мэдэгдлийн хэрэгжилтийг хангах хүрээнд Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэх хугацаа 2022.12.31-ний өдөр дуусгавар болсонтой холбогдуулан тус хуулийн хүрээнд томилогдсон 3 албан хаагчийг албан тушаалаас чөлөөлсөн.<br>4.Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулалтын зарыг Төрийн албаны зөвлөлд 8 удаа явуулсан. Удирдах албан тушаалд 2, гүйцэтгэх албан тушаалд 15 албан хаагч сонгон шалгаруулалтад оролцож, тэнцсэн. Үүнээс байгууллага дотроо ажиллаж байгаа 11 албан хаагчийг шатлан дэвшүүлж томилсон. 6 албан хаагчийг төрийн бусад байгууллага болон төрийн албанд анх орох иргэний нөөцөөс сонгон шалгаруулж томилсон.<br>5.ТАЗ-ийн 2023 оны 25 дугаар тогтоолын дагуу төрийн бусад байгууллагад ижил ангиллын албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчдаас сул орон тоог нөхөх хүрээнд тусгай шаардлага | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хангаж байгаа 1 албан хаагчийг Ахлах түшмэлийн албан тушаалд шилжүүлэн томилсон. Төрийн албаны 4 удаагийн тусгай шалгалтыг зохион байгуулж, тайланг ТАЗ-ийн хуралд танилцуулж, гарсан тогтоолын дагуу нийт 13 хүнийг Тамгын даргын тушаалаар холбогдох ажлын байранд томилсон. 6.Шинээр томилогдсон төрийн үйлчилгээний 5 албан хаагчтай Хөдөлмөрийн гэрээ байгуулах, гадаад хамтын ажиллагааны тасагт орчуулга хийх Ажил гүйцэтгэх гэрээ 2, эмчийн ажил гүйцэтгэх гэрээ 1 иргэнтэй тус тус байгуулах ажлыг зохион байгуулж, бүртгэлжүүлсэн. | |
| 7.7 | Арга хэмжээ 7.7: Комиссын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах. | Улсын төсөв | Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | Комиссын цахим хуудас шинэчлэгдсэнтэй холбогдуулан Хүний нөөцийн ил тод байдал, Авлига, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа цэсэд холбогдох мэдээлэл болон Эрх зүйн, мэдээллийн нэгдсэн систем, Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсыг тус тус холбосон.<br>Төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын сул ажлын байрны зарыг Комиссын цахим хуудас болон фейсбүүк хуудсанд 7 удаа байршуулж, нийтэд ил тод мэдээлсэн.<br>Төрийн үйлчилгээний ажлын байрны зарыг Архив, албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн группт байршуулж нийтэд мэдээлсэн.<br>Байгууллагын цахим хуудсанд 2022-2025 оны стратеги төлөвлөгөө,<br>- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний-5,<br>- Үйл ажиллагааны тайлан-13,<br>- Хяналт шинжилгээ, үнэлгээний-8,<br>- Статистик тоо, мэдээ-7,<br>- Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм-3,<br>- Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан мэдээ-2,<br>- Авлига, соён гэгээрүүлэх ажиллагаа-3,<br>- Зарлал-8,<br>- Онцлох мэдээ-4 зэрэг нийт 55 удаагийн мэдээ мэдээлэл nhrcm.gov.mn сайтад байршуулсан.<br>- Хүний эрхийн сэтгүүлчид клуб, вэб сайтын англи хувилбар дээр 10 удаагийн мэдээ мэдээлэл nhrcm.gov.mn сайтад байршуулан ажилласан байна.<br>- Комиссын цахим хуудсанд Худалдан авах ажиллагааны ил тод байдлын мэдээллийг байршуулсан. | 100 |
| 7.8 | Арга хэмжээ 7.8: Төрийн албан хаагчийн ёс зүй, хөдөлмөрийн | Улсын төсөв | Үйл ажиллагааны | 0 | 100 | Тайлант хугацаанд 2 албан хаагчид Тамгын газрын даргын тушаалаар үндсэн цалинг 1 сарын хугацаатай 20 хувь хасах | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сахилга, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авах, хяналт тавих. | | гүйцэтгэлийн хувь | | | сахилгын шийтгэл ногдуулж, 1 албан хаагчид Сануулах хуудас өгч, 3 ажилтанд тэмдэглэлээр сануулсан. Орон нутгийн 2 албан хаагчид сонсох ажиллагаа хийгдэж байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсантай холбогдуулан Тамгын даргын 2023.11.16-ны өдрийн А/113 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хороо байгуулагдсан. | |
| 7.9 | Арга хэмжээ 7.9: Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах. | Улсын төсөв | Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | Комиссын Тамгын газрын авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллав. Үүнд:<br>1.Албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн 2022 оны тайлан (ХАСХОМ-1)-г холбогдох маягтын дагуу гаргаж цаасаар, ХАС болон ХОМ-ийн хураангуй тайланг https://meduuleg.iaac.mn/ системээс татаж pdf файлаар enkhjin@iaac.mn и-мейл хаягаар тус тус илгээсэн.<br>2.Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 25 этгээдийн урьдчилсан мэдүүлэг хянаж баталгаажуулсан ирүүлсэн албан бичгийн дагуу холбогдох албан тушаалд томилсон.<br>3.Томилогдсоноос хойш 30 хоног дотор 13 албан хаагч мэдүүлэг гаргасныг хугацаанд цахим системд хянаж баталгаажуулсан.<br>4.Гэрээ байгуулах чиг үүргийн хүрээнд нийт 76, төрийн албаны тусгай шалгалт зохион байгуулах чиг үүргийн хүрээнд 25 ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдэл, тайлбар гаргасныг бүртгэлжүүлсэн.<br>5.АТГ-аас 2023.03.01-ний өдрийн 01/3476 дугаартай албан бичгээр ирүүлсэн саналын хүрээнд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн төсөлд Комиссын гишүүдээс ирүүлсэн саналыг нэгтгэн хүргүүлсэн.<br>6.ЗГ-аас 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарласантай холбогдуулан “Авлигатай тэмцэх таван ажиллагаа”-ны “Шүгэл ажиллагааны” хүрээнд АТГ-аас 2023.05.29-ний өдрөөс зохион байгуулж байгаа “Нэгдье” аяны сурталчилгааны постер, шторкийг Комиссын цахим хуудсанд байршуулсан. | 100 |
| 7.1 | Арга хэмжээ 7.10: Комиссын хуралдаан, Тамгын газрын хурлын бэлтгэл, зохион байгуулалтыг хангах, тэмдэглэл хөтлөх, гарсан шийдвэр, үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах. | Улсын төсөв | Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | Комиссын ээлжит хуралдааныг тайлант хугацаанд нийт 10 удаа зохион байгуулж 62 асуудлыг хэлэлцсэн байна. Хурлаас гарсан шийдвэрийг холбогдох албан хаагч нарт танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7.11 | Арга хэмжээ 7.11: Комиссын дарга, гишүүдэд дэмжлэг үзүүлж, албан хаагчдад үйл ажиллагаагаа тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх. | Улсын төсөв | Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | Комиссын дарга, гишүүдээс хяналт шалгалт хийх, судалгаа, дүн шинжилгээ хийх, хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, хэлэлцүүлэг зохион байгуулах, сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах, жагсаал цуглааны үйл ажиллагаанд хяналт тавьж, холбогдох мэдээ, мэдээллээр хангах зэргээр тухай бүр дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан. Комиссын дарга, гишүүдийн уулзалт, хурлын бэлтгэл, зохион байгуулалтад дэмжлэг үзүүлэн, гарсан шийдвэрийг албажуулж, тайлагнаж ажилласан. Хурлын тэмдэглэлийг мэргэжилтнүүд жагсаалтын дагуу тогтмол хөтлөн албажуулсан болно. Комиссын дарга, гишүүдийн туслах (мэргэжилтэн)-ын зүгээс давхардсан тоогоор Төрийн болон Төрийн бус байгууллагуудтай давхардсан тоогоор 300 гаруй удаагийн уулзалтад дэмжлэг үзүүлэн, шаардлагатай уулзалтын тэмдэглэл хөтлөн албажуулсан. Комиссын дарга, гишүүдийн хурал, уулзалт, хэлэлцүүлгийн мэдээллийг Комиссын албан хаагчдад тухай бүр хүргэж, нэмэлт баримт материалыг цуглуулж, бэлтгэн хавтаслан хүргүүлж, үйл ажиллагаа тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлсэн. Комиссын байр засгийн газрын 11-р байрнаас засгийн газрын 12-р байр луу нүүлгэлт, шилжүүлэлт хийгдсэнтэй холбоотой Комиссын дарга, гишүүдийн өрөөг эвдрэл, гэмтэлгүй нүүлгэн шилжүүлж, хэвийн ажиллах орчныг бүрдүүлэн ажиллаж байна | 100 |
| 7.12 | Арга хэмжээ 7.12: Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, заавар, стандартын дагуу хөтлөн явуулах, хяналт тавих, тайлагнах. | Улсын төсөв | Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 2023.01.01-ний өдрөөс 2023.12.13-ны өдрийн байдлаар ирсэн бичиг 1111, өргөдөл, гомдол 1003-г бүртгэж, гадагш явуулах 1604 албан бичиг бүртгэсэн. Үүнээс гишүүний зөвлөмж 60, шаардлага 27, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмж 20 баримт бичгийг тус тус хэвлэмэл хуудаст буулган албажуулж бүртгэсэн. Албан хэрэг хөтлөлтийн тайлан мэдээг (нийт ирсэн, явсан бичиг, өргөдөл гомдол тэдгээрийн шийдвэрлэлтийн дэлгэрэнгүй тайлан, мэдээ) 14 хоног тутам гаргаж байна.<br>Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.7 дахь хэсэгт заасны дагуу Үндэсний төв архивын дэргэдэх Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын хуралдаанаар ХЭҮК-ын 2001-2022 оны баримтын данс, бүртгэлийг хэлэлцүүлэн батлуулсан. Үүнд Хүний эрхийн үндэсний комиссын Байнга хадгалах баримтын данс 2001-2022 оны 1886 (нэг мянга найман зуун наян зургаа) хадгаламжийн нэгж, 70 жил хадгалах баримтын данс 2001-2022 оны 124 хадгаламжийн нэгж (нэг зуун хорин дөрөв), Түр хадгалах баримтын данс 2001-2022 оны 670 хадгаламжийн нэгж (зургаан зуун дал), Устгах баримтын 2001- | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2021 оны 3 хадгаламжийн нэгж (гурав) буюу 1,733 (нэг зуун далан гурав) хуудас баримтад жагсаалт үйлдэн хүргүүлж батлуулсан. Тусгай төрлийн баримтыг хөрвүүлэх ажлыг хийж гүйцэтгэх иргэнтэй байгуулах гэрээний төслийг бэлтгэн батлуулсан. Гэрээнд заагдсан төлөвлөгөөт хугацааны дагуу ажил хийгдэж байгаа бөгөөд 2023 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн байдлаар 150 ширхэг DVD,CD хөрвүүлэлтийг жагсаалтаар, мөн гэмтэлтэй болон хөрвүүлэх боломжгүй 47 ширхэг CD DVD буцаан хүлээн авсан. Архивын ерөнхий газарт шилжүүлэх 2001-2020 оны байнга хадгалах 1314 ХН-ээс 2023 оны 12 сарын 14-ны өдрийн байдлаар 699 ХН-ийг цахимжуулсан. Байгууллагын архивт түр хадгалах, 70 жил хадгалах ХН-ийг шилжүүлсэнтэй холбогдуулан баримтад тооллого хийж бүртгэл үйлдсэн. | |
| 7.13 | Арга хэмжээ 7.13: Комиссын орон нутаг дахь ажилтнуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих, тайлагнах.<br>- Орон нутгийн албан хаагчдыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах;<br>- Орон нутгийн албан хаагчдыг бүсчилсэн төлөвлөгөөний дагуу ажиллуулах. | Улсын төсөв | Бүсчилсэн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 0 | 100 | Комиссын орон нутгийн албан хаагчдын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, чадавхжуулах арга хэмжээг тусгай хөтөлбөрийн дагуу үе шаттай зохион байгуулав. Хөтөлбөрийн хүрээнд Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын Хятад, Монголыг хариуцсан товчоо, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн Бизнес ба хүний эрх төсөл, НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын газрын Иргэний орон зайн хэлтэс, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Азийн сантай хамтран Олон Улсын хөдөлмөрийн стандарт, анхаарах асуудал, Хүний эрхийн магадлан шинжилгээ түүний ач холбогдол, Иргэний оролцоог дэмжих НҮБ-ын бодлого, үйл ажиллагаа, Хүн худалдаалах гэмт хэргийн ойлголт сэдвээр сургалтууд зохион байгуулав. Түүнчлэн нийгмийн баталгааг хангах хүрээнд “Rehamed” эмнэлэгт эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамруулав. Орон нутгийн бүх албан хаагчдын ажлын хэрэгцээнд зөөврийн компьютер, өнгөт принтер шинээр олгов. Орон нутгийн албан хаагчидтай 2 долоо хоног тутам цахим уулзалт хийж, бусад нэгжтэй үйл ажиллагаагаа уялдуулан ажиллаж байна.<br>Төвийн бүс: Хүний эрхийн Түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Өвөрхангай, Өмнөговь, Төв, Дорноговь, Говьсүмбэр аймгийн ажилтнууд хамтран 2023.10 дугаар сарын 09, 10, 11-ний өдрүүдэд Өвөрхангай аймгийн Хархорин сум, Өмнөговь аймгийн Ханбогд сумдад ажиллаж, иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх, гомдол, мэдээлэл хүлээн авах, иргэд, олон нийт, төрийн байгууллага, албан тушаалтнуудын хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулахаар төлөвлөн, удирдамжийн төслийг боловсруулан хүргүүлсэн байна.<br>Хангайн бүс: Хүний эрхийн Түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Хангайн бүсийн орон нутаг дахь ажилтнууд 2023.10.11-13-ны өдрүүдэд Орхон аймгийн Төрийн байгууллагын удирдлагуудад өглөөний уулзалт болон "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ажилчид албан хаагч нарт хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулахаар үйл ажиллагааны удирдамж, хөтөлбөр, төсвийн төслийг боловсруулж Захиргаа удирдлагын хэлтсийн даргад хүргүүлсэн байна.<br>Зүүн бүс: Хүний эрхийн Түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Зүүн бүсийн орон нутаг дахь ажилтнууд 2023.11.01-07-ны өдрүүдэд Дорнод аймгийн Хуулийн байгууллагын албан хаагчдад сургалт хийх хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчлүүлэхэд шаардлагатай орчин нөхцөлд нь дүн шинжилгээ хийх, сургалтад оролцогчдын дунд ХЭТТ 75 жилийг тохиолдуулан аян зохион байгуулах уралдааныг зарлахаар үйл ажиллагааны удирдамж, хөтөлбөр, төсвийн төслийг боловсруулав. | |
| 7.14 | Арга хэмжээ 7.14: Комиссын санхүүгийн хэвийн нөхцөлийг хангаж, төсвийн төсөл болон санхүүгийн тайлан мэдээг цаг тухайд нь боловсруулах, тайлагнах. | Улсын төсөв | Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | -2024 оны төсвийн төсөл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн "хөрөнгө оруулалт"-ын саналыг УИХ-ын хууль зүйн байнгын хорооны 2023.06.27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 5,203.6 сая төгрөг байхаар шийдвэрлүүлж, төсвийн төслийн саналыг 2023.08.14-ны өдөр 01/988, 01/989 тоот албан бичгээр Сангийн яам, Үндэсний аудитын газарт тус тус хүргүүлсэн. 2024 оны Комиссын төсөв 5,117.2 сая төгрөгөөр батлагдсан. -2022 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд Үндэсний аудитын газраас "Өөрчлөлтгүй дүгнэлт" авсан. 2023 оны хагас жилийн төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайланг 2023.08.14-ны өдөр 01/990 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж цахим системд оруулсан.<br>-2023 оны хагас жилийн эд хөрөнгийн тооллогын комиссыг 2023.06.21-ны өдрийн А/77 тушаалаар батлуулж, тооллогыг зохион байгуулан холбогдох маягтын дагуу бэлтгэж Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.<br>-Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, шилэн дансны мэдээлэл, нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын тайланг 2023 онд хугацаанд нь илгээсэн.<br>-Албан хаагчдын цалинг хуваарийн дагуу бодож, олгосон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Тамгын газар батлагдсан орон тооны хүрээнд шинээр ажилд орж байгаа ажилтнуудын компьютер, тоног төхөөрөмж авах ажлын хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан авалтын захиалга өгч гэрээний хугацаанд дарааллын дагуу хүлээн авч хуваарилсан. -2023 оны 12 сарын байдлаар цалингийн зардалд 2,654.8 сая, Хангамжийн материалын зардалд 290.9 сая, Томилолт, зочны зардалд 357.4 сая, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 161.1 сая, Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 189.9 сая, Ажил олгогчоос олгох, тэтгэмжийн зардалд 33.2 сая төгрөг зарцуулсан гүйцэтгэлтэй байна. | |
| 7.15 | Арга хэмжээ 7.15: Байгууллагын дэргэдэх зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах. | Улсын төсөв | Дэд төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 0 | 100 | ССОНЗ, Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин үнэлэх үнэлгээний баг, Тусгай шалгалт зохион байгуулах ажлын хэсэг, Ёс зүйн дэд хороо батлагдсан төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. ХЭҮК-ын Тамгын газрын үйл ажиллагаанд Чанарын менежментийн тогтолцооны "ISO 9001:2015" стандартыг нэвтрүүлэх үүрэг бүхий Ажлын хэсэг, албан хаагчдын бүтээмжийг дээшлүүлэх “5S хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг ТГ-ын даргын 2023.09.08-ны өдрийн А/98 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг ТГ-ын даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>- Чанарын удирдлагын тогтолцооны сургалтыг 9 удаа зохион байгуулах;<br>- Байгууллагын дотоод орчин, гадаад орчин, оролцогч талын судалгааг хийх.<br>- Тамгын газрын Ажлын байрны 5С стандартыг батлан, Бүтээмжийн сарын аяныг зарласан.<br>- ИНЗ болон Хүний эрхийн хамгаалагчийн хорооны гишүүдийн урамшууллын журам батлагдаж урамшуулал олгосон. Баримт бичиг нягтлан шалгах комиссын 2 удаагийн хурал зохион байгуулж, архив, баримт бичгийн бүрдлийг хэлэлцэв.<br>- Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ээлжит 2 хурлыг зохион байгуулсан. “Эцэг эхийн зөвлөл”-өөс зохион байгуулсан “Олон улсын хүүхдийн эрх”-ийг хамгаалах өдрийн арга хэмжээнд гар зургийн уралдаан болон заал бэлтгэх, чимэглэл хийх, хүнсний зүйл бэлтгэх зэрэг өөрт хариуцуулсан ажлыг бүрэн хийж дуусгасан. Хүүхдийн өрөөг тохижуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7.16 | Арга хэмжээ 7.16: Комиссын дарга, гишүүдийн хамтрагч байгууллагуудтай хийх уулзалтын бэлтгэл, зохион байгуулалтыг хангах, үр дүнг тайлагнах. | Улсын төсөв | Зохион байгуулсан үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | Тайлант хугацаанд Комиссын дарга, гишүүдийн гадны байгууллагын төлөөлөлтэй хийсэн 262 удаагийн уулзалтыг зохион байгуулсан. Тамгын газрын зүгээс уулзалт бүрийн бэлтгэл зохион байгуулалтыг хангаж ажилласан. Комиссын даргын гадаад томилолтын хүрээнд хийсэн уулзалтын тэмдэглэлийг албажуулан УИХТГ-т хүргүүлж ажилласан. Комиссын дарга, гишүүдийн хамтрагч байгууллагуудтай хийсэн уулзалтын бэлтгэл, зохион байгуулалтыг хангаж, зураг дарах, дүрс бичлэг хийх зэргээр цахим Архив үүсгэн ажиллаж байна. Тайлант хугацаанд 24 уулзалт, хэлэлцүүлэг, сургалтын дүрс бичлэг, 52 уулзалт, хэлэлцүүлэг, үйл ажиллагааны зургийг баримтжуулж бүрдүүлсэн. | 100 |
| Нийт 125 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 93.8 хувь | | | | | | | |

- o O o -